

Илтгэл 52925-МН

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

2010 оны 3 дугаар сар

Дэлхийн Банк

Зүүн Ази, Номхон Далайн Бүс

Хүний Хөгжлийн Секторын Нэгж



Дэлхийн Банкны баримт бичиг

Валютын ханш

1 ам. доллар = 1,168.20 төгрөг \2007\

1 ам. доллар = 1,171.36 төгрөг \2008\

1 ам. доллар = 1,358.19 төгрөг \2009\

Санхүүгийн жил

1 сарын 1-нээс 12 сарын 31

Товчилсон үгийн тайлбар

БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөл
БСМТ-2	Боловсролын салбарын мастер төлөвлөгөө -2
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
ДББ	Дээд боловсролын байгууллагууд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МБСМАЗТ	Мэрэгжлийн боловсрол, сургалтын мэрэгжил-арга зүйн төв
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль /
МУИС	Монгол улсын Их сургууль
СТС	Сургалтын Төрийн Сан
ТМБС	Техникийн боловсрол, мэрэгжлийн сургалт
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан, техникийн их сургууль
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

Орон хариуцсан Захирал:
Секторын захирал:
Секторын менежер:
Багийн ахлагч:

Клаус Рохланд
Эммануэл Жименез
Эдуардо Велез Бастилло
Кин Бинг Ву

АГУУЛГА

Тайлангийн хураангуй

1. Ерөнхий боловсролын дараагийн шатны боловсролын асуудлууд

- 1.1. Шилжилтээс хойшхи үеийн боловсролын хөгжил
- 1.2. Дээд боловсролын бодлогын зарим асуудлууд

2. Ур чадварын эрэлт хэрэгцээ

- 2.1. Ур чадвараас шалтгаалсан орлогын ялгаа өсч байна
- 2.2. Ажлын байрны өсөлтийн хандлага
- 2.3. Цагаач ажилчид
- 2.4. Дүгнэлт

3. Дээд боловсролын чанар, тэгш байдалд удирдлага, санхүүжилт нөлөөлөх нь

- 3.1. Засаглал
- 3.2. Магадлан итгэмжлэл ба чанарын батламж
- 3.3. Санхүү
- 3.4. Сургалтын төлбөр ба оюутны санхүүгийн тусламж

4. Дээд боловсролын шинэчлэлийн бодлогын хувилбарууд

- 4.1. Дээд боловсролын байгууллагуудын чиг үүргийг ялгаатай болгох, тасралтгүй сургалтын тогтолцоог боловсронгуй болгох
- 4.2. Өрсөлдөөнд тулгуурласан санхүүжилтийг нэвтрүүлэн, хөрөнгийг цөөхөн гол сургуулиудын санхүүжилтэд төвлөрүүлэх
- 4.3. Дээд боловсролын комисс ба чанарын батламж
- 4.4. Олон нийтийн өмнө хариуцлага хүлээх, хэрэглэгчдийг хамгаалах
- 4.5. Санхүүгийн тусламжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, суурь боловсролыг сайжруулах

5. Техникийн боловсрол ба мэргэжлийн сургалт: дээд боловсролыг орлох нэг хувилбар байж болох уу?

- 5.1. Монголын ТБМС-ын тогтолцооны бүтэц ба үр дүн
- 5.2. Монголын ТМБС-ын тогтолцооны чанарын асуудлаар тулгарч байгаа асуудлууд
- 5.3. Чанар ба нийцийг сайжруулах хувилбарууд

6. Дүгнэлт

Ашигласан материал

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. Дээд боловсролын салбарын өсөлт, 1991-2009
- Хүснэгт 2. 10,000 хүнд ноогдох дээд боловсролтой хүний тоо
- Хүснэгт 3. Хамран сургалтын бохир жин, боловсролын түвшний ангиллаар, 1991, 1995, 2000 ба 2007 он
- Хүснэгт 4. Боловсролын түвшнээс хамааран олох орлогын ялгаа, 1998 ба 2007 он
- Хүснэгт 5. Боловсролын түвшнээс хамааран олох орлогын ялгаа, насны бүлгээр, 1998 ба 2007 он
- Хүснэгт 6. Цалингийн хуваарилалт, салбараар, 1998 ба 2007
- Хүснэгт 7. Боловсролын салбарын улсын төсвийн зарлага, 1991, 2002, 2007
- Хүснэгт 8: Дээд боловсролын байгууллагуудын санхүүжилтийн эх үүсвэрүүд, 2007 он
- Хүснэгт 9. Нэг оюутанд ноогдох зардлын харьцуулалт /ам. доллар/
- Хүснэгт 10. Сургалтын төрийн сангаас санхүүжилт авагчид
- Хүснэгт 11. Сургалтын төлбөрийн харьцуулалт, нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүний эзлэх хувиар
- Хүснэгт 12. Сургалтын төрийн сангийн хөрөнгийн хуваарилалт, 2007
- Хүснэгт 13. Коллежид суралцах нийт зардалд сургалтын зардлын эзлэх хувь
- Хүснэгт 14. ЭЗХАХБ-ын болон бусад зарим орны дээд боловсролын гурван талт тогтолцоо
- Хүснэгт 15. Дэлхийн тэргүүлэх сургуулиудын зэрэглэл, 2007
- Хүснэгт 16. Байршлын болон орлогын ялгаатай байдал нь боловсрол эзэмшилтийн байдалд нөлөөлж байгаа байдал
- Хүснэгт 17. Монголын ТБМС-ын гол үзүүлэлтүүд

Зургийн жагсаалт

- Зураг 1. Хамран сургалтын хувь, насны ангилалаар, 1998 ба 2007 он
- Зураг 2. 25-55 насны ажиллагсадын орлогын ялгаа, 1998-2007 / цагийн хөлс/
- Зураг 3. Дэлхийн түвшний их сургуулийн шинж чанар
- Зураг 4. Сургалтын төрийн санд хамрагдах шалгуурыг өргөжүүлсэн байдал

Хайрцгуудын жагсаалт

- Хайрцаг 1. Калифорнийн их сургуулиуд ба олон нийтийн коллежийн тогтолцоо
- Хайрцаг 2. Өрсөлдөөнт сан нь санхүүжилтийн шинэлэг хэрэгсэл мөн
- Хайрцаг 3. Шинэ Зеландын дээд боловсролын комисс
- Хайрцаг 4. Дээд боловсролын хувийн сургуулиудын чанарыг хангах Сингапурын туршлага
- Хайрцаг 5. Итали, Чилийн хөдөлмөрийн зах зээлийн ажиглалт хийдэг туршлага
- Хайрцаг 6. Сингапурын Техникийн боловсролын институтын кирриколиум боловсруулах загвар
- Хайрцаг 7. Дани улсын ТМБС-ын багш нарт тавигдах шаардлага ба сургалт
- Хайрцаг 8. Австралийн мэрэгжлийн чадамжийн бүтэц

Хавсралтын жагсаалт

- Хавсралт 1. Монгол улсын боловсролын тогтолцоо
- Хавсралт 2. Залуу болон хижээл насны насанд хүрэгчдийн сурсан жил
- Хавсралт 3. Дээд боловсрол эзэмшснээр олох орлогын ялгаа, он, насны ангилал, хүйс, ажил эрхлэлтийн салбараар
- Хавсралт 4. Элсэлтийн нэгдсэн мэдээлэл
- Хавсралт 5. Элсэлтийн мэдээлэл, түвшнээр, сургуулийн төрлөөр
- Хавсралт 6. Элсэлт, мэрэгжлийн чиглэлээр, түвшнээр
- Хавсралт 7. Санхүүгийн дэмжлэг авсан оюутнууд, түвшнээр, сургуулийн төрлөөр
- Хавсралт 8. Багш нарын боловсролын түвшин
- Хавсралт 9. Сүүлийн үеийн дэлхийн эрдэм шинжилгээний онцлох санаачлагууд

Талархал

Энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулах ажлыг Дэлхийн банкны, боловсролын салбарын тэргүүлэх мэрэгжилтэн Кин Бинг Ву удирдан гүйцэтгэлээ. Дээд боловсролын хөгжил, санхүүжилт, магадлан итгэмжлэлийн хэсгийг Пратийк Тандон бичсэн. Зөвлөх Фуук Иен Чонг техник, мэрэгжлийн боловсрол, сургалтын асуудалд үнэлгээ хийсэн. Зөвлөх Крис Сакеллариу амьжиргааны түвшингийн судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар хөдөлмөрийн зах зээлийн хандлагын талаар мэдээллийг боловсруулсан. Роберта Бассет Шинэ Зеландын дээд боловсролын комиссын талаарх мэдээллээр хангасан. Хүний хөгжлийн мэрэгжилтэн Ч. Тунгалаг баримт бичгийн агуулгад үнэтэй санал өгч, Монгол хэл дээрх орчуулгын чанарыг хянахад тусалсан. Мөн баримт бичгийг боловсруулах явцад, орон хариуцсан менежер Аршад Сайед болон үйл ажиллагааны ахлах ажилтан Жэймс Рейхерт нартай уулзаж ярилцсан болно.

Дээд боловсролын шинэчлэлийн бодлогын асуудлыг томьёолон, багийн ажиллагааг судалгаанд чиглүүлсэнд Боловсролын сайдад баг талархал илэрхийлж байна. Монголын албаны хүмүүс болон багш нар, ялангуяа БСШУЯ-ны дээд боловсролын газрын дарга М. Баасанжав, Мониторинг, үнэлгээний газрын дарга бөгөөд дээд боловсролын газрын дарга асан Р. Бат-Эрдэнэ, Хөдөөгийн боловсрол, хөгжлийн төслийн удирдагч Д. Хишигбуян, Бүх нийтийн боловсролын төлөө үр дүнд түргэн хүрэх төслийн дэд захирал О. Очирхуяг, мониторинг үнэлгээний газрын ажилтан А. Цолмон, дээд боловсролын газрын ажилтан Д. Баяр, Боловсролын дүн шинжилгээний төвийн ажилтан Ц. Эрдэнэцэцэг, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн гадаад харилцаа, магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийн ахлах мэрэгжилтэн Д. Чулуунцэцэг нарт дээд боловсролын тогтолцооны асуудлаар мэдээлэл, санал бодлоо хуваалцаж, бидэнд үнэтэй зөвлөгөө өгч байсанд талархал илэрхийлж байна. Мөн зөвлөх боловсролын мастер төлөвлөгөө, хийгдэх өөрчлөлтийн талаар санал бодлоо хуваалцсан зөвлөх Жүгдэрийн Бямбацогтод баярлалаа. Монгол улсын боловсрол, сургалтын тогтолцооны талаар өөрсдийн санаа бодлоо бидэнтэй хуваалцсан Айванху Майнз ХХК болон Монголын ажил олгогч эздийн холбооны төлөөлөгч нарт талархал илэрхийлж байна.

Энэхүү баримт бичгийг хянан тохоох ажлыг боловсролын тэргүүлэх мэрэгжилтэн Жамил Салми болон боловсролын тэргүүлэх мэрэгжилтэн Уильям Экспертон нар гүйцэтгэсэн болно.

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

1990-ээд оны эхээр төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлд суурилсан ардчилсан тогтолцоонд шилжсэн үеэс хойшхи хугацаанд Монгол улсад дээд боловсролын тогтолцоо ихээхэн өргөжсөн юм. 1992 оноос 2007 оны хооронд дээд боловсролын байгууллагуудын тоо дөрөв дахин, хамралтын тоо зургаа дахин нэмэгдэж, бохир хамралтын хувь 14 хувиас 47 хувь болж өссөн байна.

Хөдөлмөрийн зах зээл дээр өндөр ур чадварын эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь дээд боловсролын хамралтыг тэлсэн. Энэ хандлага нь дээд боловсрол эзэмших өрхийн хэрэгцээ нэмэгдэхэд түлхэц болсон. 1990-ээд оны эхээр чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж, дээд боловсролд хувийн секторын оролцоог хуульчилснаар дээд боловсрол эзэмших явц өргөжин тэлсэн байна. Гэхдээ дээд боловсролын үйлчилгээний энэхүү тэлэлт нь улсын их дээд сургуулиуд төлбөртэй сургалтад шилжиж, хувийн их дээд сургуулиудын тоо нэмэгдэх байдлаар хэрэгжсэн. Иймээс, дээд боловсролын салбарт ногдох улсын төсвийн нийт зарлагын хэмжээ 14 орчим хувьд хэвээр байна. Энэ үзүүлэлт Хятад улсад 20 хувьтай байдаг.

Хэдийгээр энэ бодлого нь дээд боловсролын эрэлт хэрэгцээг хангахад тодорхой үүрэг гүйцэтгэсэн боловч Монгол улсын олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлж чадах төгсөгчдийг бэлдэн гаргаж чадахгүй байна. Энэ бүхэн нь хямд бөгөөд чанаргүй боловсрол, зах зээл дээрх ур чадварын эрэлт хэрэгцээ болон нийлүүлэлтийн хоорондын үл зохицол, хот хөдөөгийн болон баян ядуу иргэдийн хувьд боловсрол эзэмших тэгш боломж буюу хүртээмжийн тэгш бус байдлыг бий болгосон.

- **Өнөөдөр дээд боловсролын нэг оюутанд ноогдох төсвийн зарлага 339 орчим ам. доллар байгаа нь олон улсын стандартаас доогуур байна.** Үүнтэй харьцуулахад, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын /ЭЗХАХБ/ орнуудад их дээд сургуульд суралцаж байгаа оюутанд ноогдох төсвийн зарлага 11,512 ам. доллар байна. Улсын төсвийн санхүүжилтын хүрэлцээгүй байдал болон хувийн олон жижиг байгууллагууд салбарт орж ирснээр, дээд боловсролын байгууллагуудын санхүүгийн хувьд тогтвортой оршин тогтнох асуудал нь оюутны сургалтын төлбөрт суурилж, оюутнуудын тоог олноор нэмэгдүүлэхэд хүргэж байна.
- **Үүнтэй уялдаад, мэргэжлийн өндөр чадвартай багш нарыг авч ажиллуулах, сургах ба сурах нөхцлийг сайжруулах эсвэл багш ажиллагсадын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд зарцуулах хөрөнгө нөөцийн боломж хязгаарлагдмал байна.** Улсын их дээд сургуулийн үндсэн багш нарын цалин ойролцоогоор 300 ам. доллар байгаа нь ерөнхий боловсролын сургуулийн багш нарын цалингаас багахан зөрөөтэй байна. Хувийн их дээд сургуулийн профессоруудын цалин харилцан адилгүй байдаг боловч ерөнхийдөө тийм ч өндөр биш байдаг. Улсын их дээд сургуулийн багш нарын дөнгөж 23 хувь, хувийн их дээд сургуулийн багш нарын 15 хувь нь докторын зэрэгтэй байна. Мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болон сайжруулахад зарцуулах хөрөнгийн нөөц бололцоо, хөхүүлэн дэмжих хөшүүрэг бага байна.
- **Хөдөлмөрийн зах зээлд илүү хэрэгцээтэй байгаа мэргэжлүүд болон одоо оюутнуудын суралцаж байгаа салбарууд хоорондоо нийц муутай байна.** Хувийн их

дээд сургуулиудын дийлэнх нь нийгмийн ухаан, бизнесийн мэрэгжлээр суралцуулж байгаа нь хямд өртөгтэй байдагтай холбоотой юм. Харин хөдөлмөрийн зах зээл дээр шинжлэх ухаан, технологийн мэрэгжлийн эрэлт хэрэгцээ их байгаа боловч нийт суралцагсадын дөнгөж 23 хувь нь энэ чиглэлээр суралцаж байна.

- **Их дээд сургуульд элсэгчдийн тооны өсөлт нь зах зээл дэх ажлын байрны өсөлттэй харьцуулахад илүү хурдацтай байгаа нөхцөлд чанаргүй төгсөгчдийн ирээдүй бүрхэг байна.** Их дээд сургууль төгсөгчдийн дөнгөж 36 хувь нь ажил олж байхад техник мэрэгжлийн сургууль төгсөгчдийн 60 хувь ажлын байртай болж байна. Ажлын байр олж чадсан, дээд боловсрол эзэмшигчдийн дийлэнхи нь улсын сургууль төгсөгчид байна.
- **Хэдийгээр дээд боловсролын сургалтын төлбөр өндөр байгаа ч гэсэн төлбөрийн чадвартай хотын эцэг, эхчүүд хүүхдээ их дээд сургуульд суралцуулсаар байна.** Хүн амын дөнгөж тэн хагас орчим нь хотод амьдарч байгаа ч нийт оюутнуудын 70 орчим хувь нь хотын оюутнууд байна. Улсын болон хувийн их дээд сургуулийн сургалтын төлбөр харьцангуй өндөр, сургууль сургуульд ялгаатай ч жилийн төлбөр нь дунджаар 300 орчим ам. доллар байна.
- **Сургалтын төлбөр нь өрх гэрүүдийг зээлийн дарамтад оруулж байна.** Малчдын авсан бүх зээлийн 67 орчим хувь нь дээд боловсролын сургалтын төлбөрт зориулагддаг байна.
- **Их дээд сургуулийн боловсролын чанар болон тухайн мэрэгжлээр төгсөж гарсны дараах ажлын байрны олдоцын талаархи мэдээлэл дутагдалтай байна.** Энэ тохиолдолд боловсролын хэрэглэгчид буюу эцэг эхчүүд, залуучууд тодорхой мэдээлэл дээр үндэслэн сонголт хийх боломж багатай байна.

Дээд боловсролын дэд салбарыг шинэчлэн өөрчлөх асуудал нэн чухлаар тавигдаж байна. Энэхүү бодлогын баримт бичигт сургалтын чанар, хүртээмжийн тэгш байдлыг сайжруулах талаар хэд хэдэн арга хэмжээ авахыг санал болгож байгаа юм.

Дээд боловсролын чанарыг сайжруулах нь олон улсын хэмжээнд өрсөлдөх Монгол улсын чадварыг дээшлүүлэхэд нэн чухал үүрэгтэй. Үүний тулд, стратегийн сонголтыг хийх, засаглалыг сайжруулах, дээд боловсролын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэх талаар бодолцож болох юм:

- Дээд боловсролын байгууллагуудыг зохистой тогтолцоонд оруулж, нөөц бололцоог цөөн тооны, гол сургуулиуд болон сургалтын хөтөлбөрт төвлөрүүлэх замаар олон улсын стандартад хүрэхэд нь тэдгээрт дэмжлэг үзүүлэх;
- Хамгийн сайн хөтөлбөрүүдэд хөрөнгө нөөцийг хуваарилахад /тоног төхөөрмж авах, багш нарыг сургах гэх мэт/ өрсөлдөөнт санхүүжилтийн журмыг нэвтрүүлэх, ингэхдээ гүйцэтгэлийн үнэлгээний үзүүлэлт болон зах зээлд гаргаж байгаа төгсөгчидтэй холбоотой үр дүнд суурилан, гурван жилийн циклтэйгээр санхүүжилт олгох хөтөлбөрүүдийг сонгох;

- Боловсролын магадлан итгэмжлэх болон чанарын баталгааны механизмыг боловсронгуй болгох, олон улсын жишиг стандартыг хэрэглэх замаар улсын болон хувийн дээд боловсролын байгууллагуудын тогтолцоог зохистой болгох, сайн чанарын гадаадын хөтөлбөр Монголд өрсөлдөх боломжийг нээх;
- Олон чиглэлээр төрөлжсэн, гэхдээ нэгдмэл нэг дээд боловсролын тогтолцоог хөгжүүлэх, ингэснээр дээд боловсролын байгууллага бүр бүс нутгийн хөгжилд тодорхой үүрэг гүйцэтгэх, мөн сургуулиудын хооронд шилжин суралцах боломжийг бүрдүүлэх;
- Дээд боловсролын стратегийн чиглэлийг тогтоох, засаглалыг сайжруулах, санхүүжилтийн шийдвэрийг гаргах, сургуулиудын бүс нутгийн хөгжилд гүйцэтгэж буй үүргийг хянах зорилгоор гол гол мэрэгжлийн хүмүүс болон хөгжингүй орнуудын зарим эрдэмтдийн оролцоотойгоор дээд боловсролын комиссыг байгуулах;

Хүртээмжийн тэгш байдлыг сайжруулах, хэрэглэгчдийн эрхийн хамгааллыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх:

- Сургалтын төрийн санд хамрагдах шалгуурыг чангатгах, сангийн зарцуулалтыг бага орлоготой өрхийн оюутнуудыг дэмжихэд чиглүүлэх;
- Суурь боловсролын чанарыг сайжруулах, ядуу өрхийн хүүхдүүд сургуулиа дүүргэн дараагийн шатны сургуульд элсэн суралцах боломжийг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог бий болгох, их дээд сургууль бүрийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, тухайн мэрэгжлээр төгсөгчид нь зах зээлд хэр хурдан ажил олж байгаа статистик мэдээллийг олон нийтэд хүргэх замаар оюутнуудын сурах сургууль, мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх.

Дээд боловсролын байгууллагуудын ачааллыг бууруулах, залууст өөр сонголтуудыг бий болгохын тулд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид техник, мэрэгжлийн боловсрол олгох боломжийг судалж үзэх хэрэгтэй.

Тулгарч байгаа асуудлууд, шийдвэрлэх хувилбарууд

Дэд салбар	Асуудлууд	Зөвлөмжүүд
<p>Дээд боловсрол</p>	<p>Өртөг хямд, чанар муу</p>	<ul style="list-style-type: none"> - Дээд боловсролын стратегийн чиглэлийг тогтоох, засаглалыг сайжруулах, санхүүжилтийн шийдвэрийг гаргах, сургуулиудын бүс нутгийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүргийг хянах зорилгоор гол гол мэрэгжлийн хүмүүс болон хөгжингүй орнуудын зарим эрдэмтдийн оролцоотой дээд боловсролын комиссыг байгуулах; - Хөтөлбөрийн чанар, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, сургалтын орчин зэрэг үзүүлэлтээр их дээд сургуулиудыг зэрэглэх - Их дээд сургуулиуд чанарын батламж авах, чанар сайжруулах, магадлан итгэмжлэлд хамрагдах сонирхлыг бий болгох урамшуулалын механизм нэвтрүүлэх - Их дээд сургуулиудын багш нарыг сургах, ур чадварын түвшин тогтоох, сертификат олгох үндэсний тогтолцоонд хөрөнгө оруулах замаар багш нарын мэрэгжил, мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлэх боломжийг бий болгох - Хөрөнгө нөөцийг илүү оновчтой зарцуулахын тулд өрсөлдөөнт санхүүжилтийн зарчмыг нэвтрүүлэх - Мэргэшил дээшлүүлэх богино хугацааны төлбөртэй курсүүдыг нэвтрүүлэх - Гадаадын их дээд сургуульд элсэн орсон багш нарт тэтгэлэгийн хэлбэрээр төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог системтэйгээр дэмжих /үйлдвэрийн дадлагыг хамруулан/ - Санал болгож байгаа өөрчлөлтийн хэрэгжилтийг хянах мониторинг, үнэлгээний систем бий болгох
	<p>Зах зээл дэх ур чадварын эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлтийн зөрүүтэй байдал</p>	<ul style="list-style-type: none"> - Их дээд сургуульд элсэх хүмүүст зах зээлийн талаарх мэдээлэл олгох зорилготой судалгааг санхүүжүүлэх - Төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаарх статистикийг мэрэгжлийн чиглэл, сургууль бүрээр хэвлэн нийтэлж, элсэгчдэд сургуулиа болон мэрэгжлээ сонгоход нь туслах - Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд зохицуулахын тулд оюутнуудыг холбогдох мэрэгжлүүдэд шилжүүлэн сургах

	Хүртээмжийн тэгш бус байдал	<ul style="list-style-type: none"> - Сургалтын төрийн сангийн бүтэц, чадавхи, зорилтот бүлэг, үйл ажиллагаанд шинэчлэл хийх - Сургалтын төрийн сангийн хөтөлбөр зорилтот группад чмар хэмжээгээр хүрч байгаад хяналт тавих, дүн шинжилгээ хийх тогтолцоо нэвтэрүүлэх
Техник мэргэжлийн боловсролын байгууллагууд	Дэд бүтэц, тоног төхөөрөмжийн чанар муу	<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрийн газруудаас тоног төхөөрөмжийн хандив авах - Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд хөрөнгө хуваарилах - Дэд бүтцийг сэргээн завсарлах сургалтын цехүүдийг байгуулах
	Тархай бутархай удирдлага	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөр, сертификат олгох журам, багш нарын сургалт, сургуулийн менежмент, сургалтын нөхцлийг хангах зорилгоор Техник боловсрол, мэргэжлийн сургалтын асуудал хариуцсан шинэ агентлагийг шинээр байгуулах, мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжил арга зүйн төвийг дээрх агенлагийн бүрэлдэхүүнд шингээх
	Багш нарын ур чадварыг дээшлүүлэх боломж хязгаарлагдмал	<ul style="list-style-type: none"> - Шинээр байгуулагдах Техник боловсрол, мэргэжлийн сургалтын асуудал хариуцсан шинэ агентлаг нь багш нарын мэргэжлийн түвшинд тавигдах шаардлагыг тогтоох - Одоо ажиллаж байгаа багш нарт сурган хүмүүжүүлэх/заах арга зүй болон үйлдвэрийн түншүүдтэй хамтран ажиллах замаар мэргэжил дээшлүүлэх боломжийг бүрдүүлэх - Шинээр ажилд орж байгаа багш нарыг сурган хүмүүжүүлэх болон техникийн ур чадварын сургалтад хамруулах
	Үйлдвэрийн газруудтай хамтран ажиллах явдал хязгаарлагдмал	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөрийг хянан шинэчлэх, мэргэжлийн стандартыг тогтоох, ажлын байрны сургалт хийх, шавь сургалт болон ажлын байран дээр дадлага олгох гэм сургуулиас ажилд шилжих шилжилтийн сургалтын хөтөлбөрүүдийг бий болгох
	Санхүүжилтийн үр өгөөж муу	<ul style="list-style-type: none"> - Төр-хувийн хэвшлийн түншлэл, хувийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих - Оюутнуудад сургалтын тэтгэлэг олгох тогтолцоонд өөрчлөлт оруулах замаар зах зээл дээр эрэлт хэрэгцээ ихтэй байгаа мэргэжлийн сургалтанд хөрөнгийн зарцуулалтыг илүү чиглүүлэх

1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ДАРААГИЙН ШАТНЫ БОЛОВСРОЛЫН АСУУДЛУУД

1.1. Шилжилтээс хойшхи үеийн боловсролын хөгжил

Их дээд сургуулиуд нь улс орны ирээдүйн удирдагчдийг бэлтгэн, эдийн засгийн өсөлтийн суурь болсон техникийн болон удирдлагын өндөр чадварыг бий болгодог. Их дээд сургуулиудын гүйцэтгэдэг гурван үндсэн чухал үүрэг нь сургах, нийгэмд үйлчлэх, судалгаа шинжилгээ хөгжлийн ажил байдаг. Технологийн асар хурдацтай өөрчлөлт, даяаршлын эрин үед дээд боловсролын байгууллагуудын гүйцэтгэж байгаа үүрэг нэн чухал бөгөөд тэд бүс нутгийн хөгжлийг дэмжин, үндэсний хөгжлийн механизмын чухал хэсэг болдог. Монгол улсын хувьд, улс орны эдийн засгийн хөгжилд дээд боловсролын оруулах чухал хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, эдийн засгийн өсөлтийг ханган, хөдөлмөр эрхлэлтэд тулгуурлан ядуурлыг бууруулах хүчин чармайлтын нэг чухал үндсэн элемент гэж үзэн, дээд боловсролын тогтолцооны шинэчлэлд тэргүүлэх ач холбогдол өгч байна.

1.1.1 Дээд боловсрол

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлд суурилсан эдийн засгийн харилцаанд амжилттай шилжсэн үеийн нэг амжилт нь Монгол улсын дээд боловсролын тогтолцоо хурдацтай өргөжиж, 2004 оноос 2008 оны хооронд жилд дунджаар 9 хувиар өсөж¹ ирсэн явдал юм. Хамралтын бохир хувь 1991 онд 14 хувь байсан бол 2009 онд 47 хувьд хүрсэн /Хүснэгт 1/. Нийт оюутны тоо дээрх хугацаанд 20,000-аас 150,000 болж өссөн. Ийнхүү хурдацтай өсөхөд зах зээлийн эдийн засагт өндөр мэргэшлийн ур чадварын эрэлт хэрэгцээ нэмэгдсэн, энэ нь дээд боловсрол эзэмших хэрэгцээг нэмэгдүүлсэн, мөн хувийн хэвшлийг оролцоог 1991 онд хуульчилсан зэрэг нь хүчин зүйлүүд нөлөөлсөн.

Дээд боловсролын салбарт хувийн хэвшлийн үйл ажиллагаа өсөн нэмэгдэж ирсэн ч улсын их дээд сургуулиудын жин хүчтэй хэвээр байна. Арван дөрөв байсан дээд боловсролын байгууллагуудын /ДББ/ тоо 2009 он гэхэд 151 болон нэмэгдсэний 72 хувь нь хувийн их дээд сургуулиуд байна. Монголын дээд боловсролын шатны хамралтын бохир хувь Хятадын ийм үзүүлэлтэй /23 хувь байдаг/ харьцуулахад бараг хоёр дахин өндөр, ЭЗХАХБ-ын орнуудын дундаж 55 хувьтай ойролцоо хувьд хүрээд байна. Энд тэмдэглэхэд, дээд боловсролын байгууллагуудын 72 хувь нь хувийн хэвшлийн сургуулиуд байгаа ч нийт оюутны 66 хувь нь улсын их дээд сургуульд суралцаж байна. Монголын багш оюутны тооны харьцаа 22:1 байгаа нь Өмнөд Солонгостой ойролцоо, харин ЭЗХАХБ-ын дундаж буюу 16:1 харьцаанаас арай доогуур байгаа юм. Оюутнууд санхүүгийн дэмжлэг авах боломжтой байдаг нь дээд боловсрол олж авах хүртээмжинд эерэгээр нөлөөлж байна.

¹ Засгийн газрын Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегид дээд боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилтыг дэвшүүлснээс гадна, засгийн газраас баглан гаргасан Боловсролын салбарын мастер төлөвлөгөө /БСМТ-2/ -нд дэлхийн түвшний дээд боловсролын тогтолцоог бүрдүүлэх, Монгол улсыг мэдлэгт суурилсан эдийн засаг болгон хөгжүүлэх хоёр талт зорилтыг дэвшүүлсэн юм. Дээд боловсролын тухайд, БСМТ-2-д дараах гурван үндсэн бодлогын зорилтыг дэвшүүлсэн: 1/ боловсролын чанарыг сайжруулах, орчин үеийн мэдлэгт суурилсан эдийн засгийн нөхцөлд үр дүнтэй ажиллаж чадах иргэдийг бэлтгэх, 2/ боловсролын үйлчилгээг улс орны аль ч хэсэгт, түүний дотор хөдөө орон нутгийнхан, ядуус болон эмзэг бүлгийн иргэдэд хүртээмжтэй болгох, 3/ төвийн болон орон нутгийн боловсролын байгууллагуудын менежментийн чадавхийг сайжруулах.

Хүснэгт 1. Дээд боловсролын салбарын өсөлт, 1991-2009

	1991	2009	1991-2009 оны өсөлт, хувь	2009 онд эзлэх хувь
Дээд боловсролын байгууллагын тоо	14	151	979%	100%
Улсын	14	42	200%	28%
Хувийн	-	109	-	72%
Оюутнуудын тоо	20,000	150,326	652%	100%
Улсын	20,000	99,037	395%	66%
Хувийн	-	50,878	-	34%

Эх сурвалж: БСШУЯ.

Жич: 2008 онд сургуулиудын тоо өндөр байсан, гэхдээ энд хамгийн сүүлийн шинэчилсэн мэдээг авсан.

Монголчууд дотоодын их дээд сургуулиудад суралцахаас гадна, гадаадад суралцах бас боломжтой байдаг. Социализмын үед, мянга мянган оюутнууд хуучин Зөвлөлт холбоот улс, Зүүн Европын орнууд, тухайлбал Чехословак, Зүүн Герман, Унгар, Югославт суралцдаг байсан. Засгийн газрын олон албан хаагчид гадаадын их дээд сургууль төгссөн. Шинэ тогтолцоонд шилжсний дараагаар, Орос болон шинээр үүсэн бий болон тусгаар улсуудтай боловсролын чиглэлээрх холбоо харилцаа үргэлжлэхийн сацуу Сингапур, Австрали, Англи, АНУ-д олон тооны хүмүүс суралцаж эхэлсэн юм. Эдгээр оюутнуудын дийлэнхи нь хувийн зардлаар суралцдаг ба тэдний 80 хувь Сингапурт суралцсан байна. 2010 онд Монголын Засгийн газар Фульбрайтын хөтөлбөрийн хүрээнд Монголын оюутнуудыг дипломын дараахь сургалтад АНУ-д сургах хөтөлбөр боловсруулсан. Иймээс өндөр мэргэжлийн боловсон хүчнийг зөвхөн Монголд төдийгүй, дэлхийн олон оронд сургах боломжтой байна.

Монголд дээд боловсрол ийнхүү хурдацтай хөгжиж ирсний үр дүнд, 10,000 хүнд ноогдох дээд боловсролтой хүний тоогоор зарим хөгжингүй орнууд /Солонгос, Япон, АНУ, Англи/ болон дунд орлоготой /Мексик, Бразил гэх мэт/ орнуудтай энэ зэрэгцэх хэмжээнд хүрсэн байна.

Хүснэгт 2. 10,000 хүнд ноогдох дээд боловсролтой хүний тоо

	2003	2004	2005	2006	2007
Монгол	73	84	88	91	--
Солонгос	127	126	126	125	125
Япон	81	82	83	84	83
АНУ	81	84	87	89	90
Англи	101	100	105	106	107
Мексик	34	34	37	40	--
Бразил	31	36	41	N/A	43

Эх сурвалж: Дэлхийн банкны Боловсролын Статистик мэдээллийн сан, ЭЗХАХБ Боловсролын үзүүлэлт, 2009

1.1.2 Ерөнхий боловсрол

Дээд боловсролтой харьцуулахад, шилжилтийн дараахь жилүүдэд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын байдал хүндэрч, 1990-ээд оны туршид ажиглагдсан бууралтын байдал зөвхөн сүүлийн жилүүдэд сэргэх хандлагатай болж байна /Хүснэгт 3/. Төсөв болон өрхийн зарлага хумигдаж ирсэн, хамт олон болон нийгмийн хамгааллын сүлжээ задарсан зэрэг нь энэхүү дэд салбарын эрэлт хэрэгцээ болон нийлүүлэлтийн аль алинд сөрөг үр нөлөө үзүүлсэн юм. Эл үзэгдэл 21 дүгээр зууны босгон дээр эерэг хандлагад орж эхэлсэн.

Хүснэгт 3. Хамран сургалтын бохир жин, боловсролын түвшний ангиллаар, 1991, 1995, 2000 ба 2007 он

	СӨБ	Бага	Дунд	Ахлах	Дээд
1991	39%	97%	82%	69%	14%
1995	21%	88%	59%	21%	15%
2000	28%	99%	63%	28%	29%
2007	54%	94%	89%	54%	47%


Эх сурвалж: БСШУЯ-ны 2008 оны статистик мэдээ

Жич: Хамралтын бохир жин 2007 онд 94% болсон нь 2004-2005 онд ерөнхий боловсролын сургуульд элсэх насыг 8-аас 7, 2008-2009 онд 7-оос 6 болгон бууруулсантай холбоотой. Энэ өөрчлөлттэй холбоотойгоор сургуульд хамрагдах ёстой нийт хүүхдийн тоо нэмэгдсэн нь хамралтын хувь өөрчлөгдөхөд нөлөөлсөн. Гэхдээ энэ нь хамралт буурсан гэсэн үг биш юм.

Монголын Засгийн газар сургуулийн насны бүх хүүхдэд суралцах тэгш боломж олгох, хүний капиталыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх зорилгын хүрээнд чанартай суурь боловсрол олгохын ач холбогдлыг бүрэн хүлээн зөвшөөрч, бүтцийн чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсэн юм. 2004-2005 оны хичээлийн жилд 10 жилийн сургалтыг 11 жил, 2008-2009 оны хичээлийн жилд 12 жилийн сургалтанд шилжүүлснээр үүнээс өмнө Монголд баримталж ирсэн бага ба дунд боловсролын хэт богино /10 жилийн/ тогтолцоог халсан юм.

1998 болон 2007 онд явуулсан Амьжиргааны түвшний судалгаанд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд боловсролын нөхцөл сайжирч, сургуульд элсэн орох нас буурсны үр дүнд сурагчдын тоо өсөж, сургуульд нийт суралцах хугацаа нь уртассан байна /Зураг 1/. Түүнчлэн, ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс их дээд сургуульд орсон залуусын тоо нэмэгдсэн байна. Энэ байдал охид, хөвгүүдийн аль алинд ажиглагдаж байна /Хавсралт 4, Хүснэгт А4.6/. 1998 онтой харьцуулахад, 2007 онд хүйсийн ялгаа хамран сургалтын жинд илүү тод гарч ирсэн. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчид болон их дээд сургуульд суралцагчдын дунд охидын тоо хөвгүүдийнхээс давамгайлах болсон. Хөдөөд ч сургуулийн хамран сургалт илт нэмэгдсэн /Хавсралт 4, Хүснэгт А4.6/. 1998 онтой харьцуулахад 2007 он гэхэд сургуулийн хамран сургалт хот, хөдөөгийн аль алинд өссөн бөгөөд ялангуяа хөдөөд дунд сургуулийн хамран сургалт илүү нэмэгдэж, тогтвортой үргэлжлэн суралцсан байна.

Зураг 1. Хамран сургалтын хувь, насны ангилалаар, 1998 ба 2007 он



Эх сурвалж: Амьжиргааны түвшиний судалгаа, 1998, 2007

Зураг 1-ээс харахад, 8-15 насны бүлгийн хувьд хамран сургалтын түвшин 100 хувьд хүрэхгүй байна. 14-нас хүрэх үеэс эхлээд хөвгүүд, охидын элсэлт хот, хөдөөд буурч эхэлж байгаа бөгөөд сургуульдаа үргэлжлүүлэн суралцах нь хотод илүү жинтэй байна. Бүхэлд нь авч үзвэл, Монгол улсад ерөнхий боловсрол бүрэн эзэмших хувь дөнгөж 77 хувьтай байгаа нь шилжилтийн эдийн засагтай бусад орнуудтай /Арменид 87 хувь, Тажикстанд 90 хувь/ харьцуулахад доогуур байна. Энэ бүхэн нь Монгол улсын хувьд ерөнхий боловсрол ба дээд боловсролын бодлогод дунд хугацаанд бэрхшээлтэй асуудлууд байгаагийн илэрхийлэл бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн /ЕБС/-ийн дараагийн шатны сургуульд элсэн суралцах байдал хот, хөдөөд ялгаатай байгаагийн нэг тайлбар байж болох юм.

Хүн ам зүйн хандлагаас харахад, 2010 оны байдлаар 20-24 насны залуучуудын тоо 342,000 буюу нийт хүн амын 13 орчим хувийг эзлэж байна /АНУ-ын Хүн ам тооллогын албаны мэдээлэл, Хавсралт 2/. Тиймээс ч дээд боловсролын нийгмийн хэрэгцээ шаардлага өндөр байна. 2020 он гэхэд, энэ бүлгийн тоо 283,000 болж буурах төлөвтэй байгаа нь энэ дэд салбарын ачааллыг тодорхой хэмжээгээр багасгах юм. Энэ нь чанарыг дээшлүүлэхэд илүү анхаарах, дээд боловсролын хамралтын бохир жинг нэмэгдүүлэх боломж олгох юм. Үүний зэрэгцээ, төрөлт 2.24 хувь байгаа нь сургуулийн насны хүүхдийн тоог бараг 40 хувиар нэмэгдүүлэх болно /Хавсралт 2/. Тийм учраас ирэх арваад жилд ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдийн тоо илт нэмэгдэхтэй холбогдсон зохицуулалтыг боловсролын тогтолцоонд хийх шаардлага тулгарч байна.

Энэхүү бодлогын баримт бичигт дээд боловсролын асуудалд гол анхаарлыг төвлөрүүлж байгаа ч зах зээлийн шаардлага, эцэг эх болон суралцагсдын сурах хэрэгцээ, эрмэлзлэлийг харгалзах бодлогын хувилбаруудыг авч үзэх зорилгын хүрээнд техникийн боловсрол, мэрэгжлийн сургалтын /ТБМС/ асуудлыг мөн авч үзэж байгаа юм.

1.2 Дээд боловсролын бодлогын зарим асуудлууд

Монголын дээд боловсролын туулж өнгөрүүлсэн замналыг авч үзэхэд дээд боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байгаа гурван хүчин зүйл байна: 1. Өртөг багатай, чанар муу байдал, 2. ур чадварын эрэлт хэрэгцээ болон нийлүүлэлтийн хоорондын үл нийцэл, 3. тэгш бус хүртээмж /энэ нь баян ядуугийн болон хот хөдөөгийн ялгааг улам нэмэгдүүлж байна/.

Өртөг бага, чанар муу: Нэгдүгээрт энэ дэд салбарын огцом тэлэлт нь бага зардал, муу чанартай явж ирсэн. Санхүүжилтын хомсдолтой байдлаас үүдэн, дээд боловсролын нэг оюутанд ноогдох төсвийн зарлага ойролцоогоор 339 ам. доллар байгаа нь бага сургуулийн нэг сурагчид ноогдох 206 ам. долларын зарлага, дунд сургуулийн нэг сурагчид ноогдох 285 ам. долларын зарлагаас яльгүй өндөр байна. Энэ нь ЭЗХАХБ-ын дундаж 11,512 доллар /Хүснэгт 8/-аас хэтэрхий доогуур байна. Дээд боловсролын байгууллагуудын ингэж бага зардлаар ажилладаг байдал нь чадварлаг багш нарыг өндөр цалингаар татах, сургалтын орчинг сайжруулах хөрөнгө оруулалт хийх болон ажиллагсдын мэрэгжил дээшлүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлж байна. Улсын болон хувийн их дээд сургуулийн үндсэн багш нарын сарын цалин ойролцоогоор 300 доллар байгаа нь ерөнхий боловсролын сургуулийн багш нарын цалингаас тун бага ялгаатай байна. Санхүүжилтын хомсдлын улмаас улсын их дээд сургуулиуд ч санхүүгийн хувьд тогтвортой оршин тогтнохын тулд сургалтын төлбөр төлдөг оюутнуудыг олноор элсүүлэн авч байна.

Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт хэрэгцээнд нийцсэн ур чадварыг нийлүүлж чадахгүй байна: Бага зардалтай, чанар муутай энэ тогтолцоо нь оршин тогтнохын тулд олон тооны оюутан элсүүлэн авдаг нь зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хэтэрсэн, чанар муутай, ажлын байртай болох магадлал бүрхэг төгсөгчдийг гаргаж байна. Сүүлийн жилүүдэд их дээд сургууль төгсөгчдийн зөвхөн 36 орчим хувь нь ажлын байр олж чадсан байна \БСШУЯ 2008\.

Энэ нь эрэлт хэрэгцээ бага мэрэгжлээр олон тооны, чанар муутай төгсөгчид гаргаж байгаатай холбоотой юм. Харин 2008 оны байдлаар ТМБС төгсөгчдийн 60 хувь² нь ажлын байртай болж байна.

Монгол улсын хөдөлмөрлөх хүчний судалгаанаас харахад, 2002-2003 онд ажилгүй байсан иргэдийн олонх нь бүрэн бус /34 хувь/ болон бүрэн дунд /33 хувь/ боловсролтой байна. Сургуулиас ажилд шилжих шилжилтийн судалгаанаас үзэхэд, 15-29 насны хүмүүсийн дунд, ажилгүйдлийн түвшингийн хувьд ЕБС төгсөгчидтэй /22 хувь/ харьцуулахад техник мэрэгжлийн сургууль төгсөгчдийн эзлэх жин бага /15 хувь/, дээд боловсролтой /12 хувь/ хүмүүстэй харьцуулахад техникийн дипломтай хүмүүсийн эзлэх хувь бага /8 хувь/ байна. Их дээд сургууль болон ТМБС төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дэх дээрх байдал нь зах зээлийн эрэлт хэрэгцээ болон нийлүүлэлтийн зохицлын чухлыг харуулж байна.

Тэгш бус хүртээмж: Их дээд сургуульд элсэн суралцах байдал хот, хөдөөгийн хооронд болон орлого ихтэй болон орлого бага бүлгүүдийн хооронд ихээхэн ялгаатай байна. Хэдийгээр ЕБС-аас дараагийн шатны боловсролд бүх нийтийг хамруулахыг хэзээ ч зорьдоггүй ч, их дээд сургуульд элсэн суралцах боломж үнэхээр тэгш бус байна. Хүн амын тэн хагас нь хөдөө орон

² Энэ тоог БСШУЯ-ны албан ёсны статистик мэдээнээс авсан. Саяхан Дэлхийн банкны баг Улаанбаатар, Сэлэнгэ аймгийн ТБМС-тай танилцсан. Тэдний мэдэгдэж байгаагаар төгсөгчдийн талаар ямар нэг албан ёсны судалгаа байхгүй ч, албан бус мэдээллээр төгсөгчдийн 80 илүү хувь нь ажилтай болдог байна. БСШУЯ-ны мониторинг, үнэлгээний газар ТБМС төгсөгчдийн талаар ямар нэг албан ёсны мэдээлэл байхгүй гэдгийг нотолж байна.

нутагт амьдарч байхад их дээд сургуулийн оюутнуудын 71 хувь нь хотын оюутнууд байна. Энэ нь хөдөөд сурлагын чанар муу, ЕБС төгсөгчдийн хувь доогуур байгаатай гол нь холбоотой. Сургалтын төлбөрийн асуудал тэдний сурах эрмэлзлэлийг ихээхэн боогдуулж байна. Сургалтын жилийн төлбөр ойролцоогоор 300 орчим ам. доллар байна. Олон хүүхэдтэй малчин өрхийн хувьд хүүхдүүдээ их дээд сургуульд сургахад санхүүгийн хувьд туйлын хүндрэлтэй. Малчдын, банкнаас авсан зээлийн 67 орчим хувь нь их дээд сургуулийн сургалтын зардалд зориулагдсан байна.

Сургалтын төрийн сан /СТС/ нь бага орлоготой өрхийн оюутны төлбөрийг нимгэлэхэд ихээхэн дэмжлэг болж байгааг энд тэмдэглэж байна. Гэхдээ энэ сангийн товлосон зорилтот бүлэг нь тодорхой бус, хамрах хүрээ өргөн, үүнд төрийн албан хаагчид ч бас ордог.

Улс орны эдийн засгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, Монгол улсын өрсөлдөх чадварыг сайжруулж чадах мэрэгжлийн боловсон хүчнийг бэлтгэн гаргахын тулд дээд боловсролын сургалтын чанарыг эрс дээшлүүлэх шаардлагатай гэдгийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөөд байна. Түүнчлэн хүртээмжийн тэгш байдал болон төсвийн хөрөнгийн зарцуулалтыг үр дүнтэй болгох шаардлагатай. Үүнтэй холбогдон бодлогын чанартай, дараах хоёр багц асуулт тавигдаж байна.

- Ажил эрхлэлтийн хувь доогуур байгаа өнөөгийн нөхцөлд дээд боловсролтой боловсон хүчний нийлүүлэлт нь эрэлт хэрэгцээнээс давж байна уу? Их дээд сургуулийн элсэлтийг тодорхой хэмжээнд барих хэрэгтэй юү? Хэрэв тийм бодлого хэрэггүй бол чанарыг сайжруулах ямар хувилбар байж болох вэ?
- Эдийн засгийн эрэлт хэрэгцээ болон эцэг эх, залуучуудын ажил эрхлэх хүсэл эрмэлзэлд нийцсэн өөр ямар хувилбар байж болох вэ?

Энэхүү судалгааны хүрээнд дээр дурьдсан бодлогын асуудлуудад хариулт өгөх, бодлогын хувилбаруудыг үнэлэхийн тулд дараахь асуудлуудыг авч үзлээ. Үүнд:

- **Ур чадварын эрэлт хэрэгцээ:** 25-34 насны бүлгийнхэн 35-55 насны бүлэгтэй харьцуулахад ямар хэмжээний орлого олж байна вэ? Энэ нь ур чадварын эрэлт хэрэгцээтэй ямар холбоотой, цаашлаад дээд болон техникийн боловсрол, мэрэгжлийн сургалтын бодлогод яаж нөлөөлөх вэ?
- **Дээд боловсролын чанар, тэгш хамралтад засаглал, санхүүжилтын нөлөө:** Дээд боловсролыг хэрхэн удирдаж байна вэ? Дээд боловсролын байгууллагуудын тоо хурдацтай өсөж байгаа нь улсын болон хувийн дээд сургуулиудын санхүүжилтэд хэрхэн нөлөөлсөн бэ? Санхүүжилтийн энэ чиг хандлага нь сургалтын чанар, тэгш хамралтад хэрхэн нөлөөлсөн бэ? Магадлан итгэмжлэлийн өнөөгийн тогтолцоо чанарын баталгааг хангаж чадаж байна уу?
- **Шинэчлэлийн бодлогын хувилбарууд:** Хямд өртөг, чанар муутай дээд боловсролын өнөөгийн тогтолцоог шинэчлэхийн тулд дээд боловсролын засаглал, санхүүжилтийн талаар болон хэрэглэгчдийг хамгаалах үүднээс юу хийх хэрэгтэй вэ?
- **ТМБС нь дээд боловсролын альтернатив хувилбар байж болох уу:** Оюутнуудыг дээд боловсрол зэмших гэхээс илүүтэй ТБМС руу илүү чиглүүлэх боломжтой юү?

ТМБС-нд ямар асуудлууд тулгараад байна? Тэдгээрийг шийдвэрлэхийн тулд юу хийх шаардлагатай вэ?


2. УР ЧАДВАРЫН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ

1990-ээд оны эхээр, нээлттэй эдийн засгийг хөгжүүлж эхэлснээс хойш мэрэгжилтэй боловсон хүчний эрэлт шаардлага эрс нэмэгдсэн. Энэ нь дээд боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгдэх хүчин зүйлийн нэг болсон байна. Өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг илүү сайн ойлгох нь чухам ямар дэд салбар, ямар мэрэгжилд хөрөнгө оруулалт хийх, зохицуулалтын ямар арга хэмжээ авах шаардлагатайг тодорхойлоход тус болно.

2.1. Ур чадвараас шалтгаалсан орлогын ялгаа өсч байна

Дэлхийн банкнаас хийсэн, амьжиргааны түвшний судалгаанаас үзэхэд 1998-2007 оны хооронд ахимаг настай ажиллагсдын цалингийн түвшин нэмэгдсэн байна. /Зураг 2/

Зураг 2. 25-55 насны ажиллагсдын орлогын ялгаа , 1998-2007 / цагийн хөлс/



Эх сурвалж: Амьжиргааны түвшний судалгаа, 1998, 2007

Дээд боловсролтой хүний цалин боловсролгүй болон боловсролын өөр түвшний ажиллагсадтай харьцуулахад өндөр байна. 1998-2007 оны хооронд дараахь хандлага ажиглагдаж байна /Хүснэгт 4/. Үүнд:

- Бүрэн бус боловсролтой хүмүүсийн орлогыг бага боловсролтой хүмүүсийнхтэй харьцуулахад ялгаа нь буурч байна /-0.231/.
- Мэрэгжлийн сургалттай ЕБС /0.349/ болон ердийн ЕБС төгсөгчдийн /0.093/ орлогыг бага боловсролтой хүмүүсийнхтэй харьцуулахад ялгаа нь нэмэгдэж байгаа нь ЕБС-

ийн ахлах ангид суралцагчдын хувьд мэрэгжлийн ур чадвар зээмших шаардлага өндөр болж байгаагийн дохио юм.

- Дээд болон бага боловсролтой хүмүүсийн орлогын зөрүү нь мэрэгжлийн боловсролтой хүмүүсийнхтэй харьцуулахад бага байна /0.408/.
- Бага боловсролтой хүмүүсийнхтэй харьцуулахад ТБМС төгсөгчдийн хувьд хамгийн их ялгаатай байгаа нь /0.639/ насанд хүрсэн нийт ажиллагсдын дотор хамгийн өндөр байгаа юм.

Хүснэгт 4: Боловсролын түвшнээс хамааран олох орлогын ялгаа, 1998 ба 2007 он

	1998	2007	1998-2007 өөрчлөлт
Бага	-0.250	0.116	0.366
Бүрэн бус дунд /бага	0.521	0.290*	-0.231
Бүрэн дунд /бага	0.603	0.786*	0.183
ЕБС/ бага	0.650	0.743*	0.093
Мэрэгжлийн сургалттай ЕБС/ бага	0.525	0.874*	0.349
Дээд болосролын диплом/ бага	0.667*	1.306*	0.639
Их сургууль/ бага	0.979*	1.387*	0.408

*Бага боловсролоос бусад түвшинд статистикийн ач холбогдолтой.

Эх сурвалж: Сакеллариу, 2009. Дэлхийн Банкнаас бүсийн хэмжээнд хийсэн үйлдвэрлэл, мэрэгжлийн ур чадварын судалгаа.

Дээрх мэдээллээс харахад, мэрэгжлийн өндөр ур чадвар, ялангуяа ТБМС–аар олгох ур чадварын эрэлт хэрэгцээ улам бүр өсөж байна. Ур чадвар өндөр байх тутам олох орлогын ялгаа ихсэх хандлагатай байхад дээд боловсролтой төгсөгчдийн ажил эрхлэлт бага байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээл илүү боловсролтой төгсөгчид гэхээсээ илүүтэйгээр өндөр ур чадвартай төгсөгчдийг сонгон авч байгааг харуулж байна.

Энэ чиглэлээрх судалгаанаас ажиглагдсан нэг сонирхолтой хандлага нь ахмад болон залуучууд, эрэгтэй болон эмэгтэй ажиллагсдын олох орлогын ялгааны асуудал юм. /Хүснэгт 5 ба хавсралт 3/

- 25-34 насны, дээд боловсролтой эрэгтэйчүүдийн хувьд 1998-2007 оны хооронд гарсан орлогын ялгаа нэлээд өссөн байна. Энэ нь дээд боловсрол эзэмших өрхийн эрэлт хэрэгцээ нэмэгдснийг тайлбарлах нэг хүчин зүйл байж болох юм.
- Дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд 1998-2007 оны хооронд гарсан цалингийн өсөлт нь харьцангуй бага /бараг 10 хувь/, гэхдээ орлогын ялгаанд гарсан өөрчлөлт /1.22/ нь эрэгтэйчүүдээс илүү /0.68/ байна. /Хавсралт 3, Хүснэгт А1 ба 2/
- Дээрхи хугацаанд, хувийн хэвшилд ажиллагсдын цалин илүү өндөр байна.

- 35-55 насны бүлгийн хувьд эрэгтэйчүүдийн орлогод гарсан ялгаа нь эмэгтэйчүүдийнхээс илүү байна.
- Улсын секторт ажиллагсдын цалингийн өсөлт нь хувийн хэвшлийнхнээс илүү байна.

Хүснэгт 5: Боловсролын түвшнээс хамааран олох орлогын ялгаа, насны бүлгээр, 1998 ба 2007 он

Боловсролгүй хүмүүстэй харьцуулахад:	1998	2007	Өөрчлөлт (%) (1998-07)
<u>25-34 насны бүлэг</u>			
Бага (тооцоогүй)		-0.304	-
Бүрэн бус дунд	0.515	-0.082	
Бүрэн дунд	0.392	0.458*	16.84
Мэрэгжлийн сургалттай ЕБС	0.376	0.679***	80.6
Дээд боловсролын диплом	0.531	1.01***	90.2
Их сургууль	0.827	1.18***	42.7
R-квд	0.025	0.180	
N	384	2,549	
<u>35-55 насны бүлэг</u>			
Бага	0.839	0.172	-79.5
Бүрэн бус дунд	1.34**	0.554***	-58.7
Бүрэн дунд	1.63***	0.976***	-40.1
Мэрэгжлийн сургалттай ЕБС	1.45**	1.15***	-20.7
Дээд боловсролын диплом	1.61***	1.64**	1.8
Их сургууль	1.94***	1.69***	-12.9
R-квд	0.100	0.157	
N	702	4,739	

Жич: Статистикийн ач холбогдол багатай өөрчлөлтийн хувийг тооцоогүй болно.

Эх сурвалж: Амьжиргааны түвшний судалгаа, 1998, 2007

2.2. Ажлын байрны өсөлтийн хандлага

Чухам аль салбарт ажлын байр нэмэгдэж байна вэ? Амьжиргааны түвшний судалгаанаас үзэхэд, уул уурхайн салбарт хамгийн өндөр өсөлттэй буюу 25-34 насны бүлгийн хувьд ажил эрхлэлт 1998- 2007 оны хооронд 671 хувь нэмэгдсэн байна /Хүснэгт 6/. Уул уурхайн салбарын

хувьд залуусын ажил эрхлэлт ахмад насны бүлгээс дээгүүр байгаа нь 35-55 насны бүлгийн ажил эрхлэлтийн өсөлт 295 хувь байгаагаас харагдаж байна /Хүснэгт 6/. 1998-2007 оны хооронд 25-34 насны бүлгийн хувьд, ажлын байрны өсөлтөөр барилгын салбар хоёрдугаарт орж байгаа бөгөөд /368 хувь/, тээвэр, харилцаа холбооны салбар гуравдугаарт /110 хувь/ орж байна. Эндээс харахад, хөдөлмөрийн зах зээлд техник, мэрэгжлийн болон инженерийн боловсролтой залуу хүмүүсийг шингээх илүү боломж байна.

Хүснэгт 6: Цалингийн хуваарилалт, салбараар, 1998 ба 2007 он

Үйлдвэрлэл	1998 (%)	2007 (%)	өөрчлөлт (%) (1998-07)
25-34 насны бүлэг	(n=383)	(n=2,579)	
Хөдөө аж ахуй	4.18	1.86	-55.5
Уул уурхай	0.78	6.01	670.5
Жижиг үйлдвэрлэл	4.69	9.93	111.7
Ахуйн үйлчилгээ	3.39	3.44	1.5
Барилга	2.08	9.74	368.3
Худалдаа	9.89	11.02	11.4
Тээвэр/Холбоо	6.77	14.19	109.6
Төрийн захиргаа	25.52	9.55	-62.6
Үйлчилгээ	42.56	34.25	-19.5
35-55 насны бүлэг	(n=700)	(n=4,780)	
Хөдөө аж ахуй	6.43	3.28	-49.0
Уул уурхай	1.28	5.06	295.3
Жижиг үйлдвэрлэл	4.70	9.50	102.1
Ахуйн үйлчилгээ	3.85	5.84	51.7
Барилга	3.56	8.37	135.1
Худалдаа	5.13	7.85	53.0
Тээвэр/Холбоо	7.26	10.66	46.8
Төрийн захиргаа	22.36	10.91	-51.2
Үйлчилгээ	45.29	38.52	-14.9

Эх сурвалж: Амьжиргааны түвшний судалгаа, 1998, 2007

Хөдөлмөрийн зах зээлийн дээрх дүр зураг нь нь эдгээр салбаруудын эдийн засагт гүйцэтгэх ач холбогдол нэмэгдэж байгааг харуулж байна. Монгол улс нь зэс, нүүрс, алт, уран зэрэг эрдэс баялаг ихтэй. Уул уурхайн салбараас орох орлого, жишээ нь 2008 онд улсын төсвийн бараг 45 хувийг, ДНБ-ий бараг 29 хувийг эзэлж байлаа. 2008 онд Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр ганцаараа ДНБ-ий 12 хувийг, тээвэр, харилцаа холбооны салбар ДНБ-ний бараг 13 хувийг бүрдүүлсэн байна.

Энэ хандлага цаашдаа ч үргэлжлэх төлөвтэй байна. Гадаадын хөрөнгө оруулагчид нүүрс, алт, зэсийн томоохон ордууд бүхий Өмнөд говийг улам их сонирхох болж байна. Дэлхийн Банкны Монголын Өмнөд говийн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн стратегид цохон тэмдэглэсэнээр, энэ бүс нутагт уул уурхай, барилгын мэрэгжилтэй ажилчдын эрэлт хэрэгцээ маш өндөр байгаа бөгөөд

наад зах нь 7000 ажилчин шинээр авч ажиллуулах шаардлага байна. Эдгээр ажилчид нь уурхайг тойрон бий болох хотхон, зам, дэд бүтцийг хөгжүүлэх болон уул уурхайн тоног төхөөрөмжийг ажиллуулах, тэдгээрийн ашиглалт үйлчилгээний ажилд шаардлагатай байна. Үүнээс гадна, гаднаас ирж ажиллаж байгаа ажилчдын тоо өсөн нэмэгдэж байгаатай уялдан, орон нутгийн ажиллагсдыг сургах нөхцлийг бий болгох, уул уурхайтай холбогдсон шинээр бий болж буй ажлын байруудад орон нутгийн иргэдийг авч ажиллуулахад анхаарах, тэднийг сургаж бэлдэх замаар уул уурхайн салбарт ажиллах мэрэгжлийн ур чадвартай ажиллагсдыг нийлүүлэх явдал чухлаар тавигдаж байна.

Дунд хугацаанд, уул уурхайн компаниуд энэ салбарт томоохон өөрчлөлт хийхээр бэлдэж байна. Айванху Майнз Монголия ХХК, жишээ нь, үйл ажиллагаа жигдрэх үедээ 3000 ажилчин авах, уурхайн Өмнөд говийн бүсийн барилга байгууламжийн үе шатанд 8000 ажилчин авч ажиллуулахаар төлөвлөж байна. Энержи Ресурс ХХК-ний хувьд, мөн ийм үсрэлтийн дүр зураг харагдаж байгаа бөгөөд одоогийн ажиллагсдын тоог хоёр дахин нэмэгдүүлж 2009 оны эцэс гэхэд 800-д хүргэх, гурван жилийн дараа 1500-д хүргэхээр төлөвлөж байна. Энэ хоёр компаний хувьд сэтгэл зовоож байгаа асуудал нь мэрэгжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангах ажилчдыг олж ажиллуулах явдал бөгөөд БСШУЯ-тай хамтран уул уурхайн ажилчид бэлтгэх сургалтыг идэвхижүүлэх сонирхолтой байна. Эдгээр компаниуд нь Монголоос мэрэгжлийн ажилчид авах бололцоо бүрэлдэх хүртэл гадаадаас /ихэвчлэн хөрш Хятадаас/ ажилчид авахаар төлөвлөж байна.³

Монгол улсын 8300 гаруй бизнесийн ашиг сонирхлыг нэгтгэсэн Монголын ажил олгогч эздийн холбоо /төрийн бус байгууллага/-ны зүгээс ажил олгогчдын хүсэн хүлээж байгаа мэрэгжлийн ур чадвар болон ТБМС төгсөгчдийн мэдлэг, чадварын хооронд ихээхэн ялгаа байгааг хүлээн зөвшөөрч байна. ТБМС төгсөгчид нь ажлын байрны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал болон өндөр технологийн талаар мэдлэг, чадвар дутагдалтай байдаг бөгөөд энэ дэд салбарын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ажил олгогчдын зүгээс тэмдэглэж байгаа эдгээр асуудлуудыг суралцагсдын мэрэгжлийн талаарх мэдээлэл баталж байна /Хавсралт 5/. 2008 оны байдлаар, нийт суралцагсдын дөнгөж 23 хувь нь шинжлэх ухаан, технологийн салбарт /ажил олгогчдод илүү шаардлагатай мэрэгжлүүд/ ноогдож байхад 50 гаруй хувь нь нийгмийн ухаан, урлаг гэх мэт /эрэлт хэрэгцээ багатай/ салбарт ноогдож байна. Төгсөгчдийн мэрэгжил болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ нийцэхгүй байгаа нь эндээс харахад тодорхой харагдаж байна.

Энэ бүхнээс үзэхэд дээд боловсролын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээтэй уялдуулах шаардлага чухлаар тавигдаж байна. Ийм шинэчлэлийг хийхэд шаардлагатай арга замуудын талаар дараагийн хэсгүүдэд тодорхой авч үзнэ.

2.3. Цагаач ажилчид

Хөдөлмөрийн зах зээлийн талаарх өмнө яригдсан асуудлуудад цагаач ажилчдын асуудал тусаагүй болно. Монголын цагаач ажилчдын хувьд Өмнөд Солонгос чухал байр суурь эзэлдэг. Одоогийн байдлаар ойролцоогоор 30,000 гаруй Монголчууд тэнд ажиллаж байна. Хувиараа ажил

³ Уурхайн албан хаагчтай хийсэн ярилцлага

эрхлэгчид болон малчдыг оролцуулахгүйгээр тооцоход, Өмнөд Солонгост ажил хийж байгаа хүмүүс нийт ажил эрхэлж буй хүмүүсийн тоог 6 хувиар нэмэгдүүлэх юм. Үүнээс гадна, хөрш зэргэлдээ болон бусад орнуудад ажиллаж байгаа Монголчууд олон байгаа боловч тэдний талаар тодорхой статистик мэдээ байхгүй байна.

Үүний зэрэгцээ, 15,000 орчим Хятадын цагаач ажилчид Монголд ажиллаж байгаагийн олонхи нь барилгын салбарт байна. Хятадын цагаач ажилчдын хийж байгаа зарим ажил нь бага хөлстэй байгаа нь Монгол ажилчдыг татахгүй байгаа юм. Нөгөө талдаа, мэрэгжлийн ур чадвар шаардсан бусад ажлуудын хувьд ажлын байрны шаардлагыг хангах Монгол ажилчид ховор байна.

Даяаршлын энэ эрин үед, боловсролын бодлогыг төлөвлөхөд зөвхөн дотоодын хөдөлмөрийн зах зээлийг анхаарах нь хангалтгүй юм. Цагаач ажилчдын эх орондоо шилжүүлж байгаа мөнгө нь олон өрхийн орлогын нэг эх үүсвэр болохын зэрэгцээ дотоодын хөдөлмөрийн зах зээлийн ачааллыг багасгаж байдаг. Жишээ нь, Ойрхи Дорнод, Зүүн Өмнөд Азид их хэмжээгээр гарч ажилладаг Бангладешд цагаач ажилчдын эх орон руугаа гуйвуулж байгаа мөнгө ДНБ-ний 10 хувийг эзэлж байна. Тийм учраас, боловсролын бодлого боловсруулахад гадаад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг ч бас харгалзан үзэх нь зүйтэй юм.

2.4. Дүгнэлт

Энэ бүхнээс харахад, дээд боловсролын чанарыг эрс сайжруулж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлэх явдал чухлаар тавигдаж байна. Энэ зорилгод хүрэхийн тулд зөвхөн дээд боловсролын салбарт төдийгүй техникийн боловсрол, мэрэгжлийн сургалтын салбарт ч хэд хэдэн чухал шинэчлэлийг хийх шаардлагатай байна.

3. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ТЭГШ БАЙДАЛД УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТ НӨЛӨӨЛӨХ НЬ

Удирдлага болон санхүүжилт нь боловсролын чанарт нөлөөлдөг. Дэлхийн банкнаас хийсэн судалгаанаас харахад, дэлхийн зэрэглэлийн их дээд сургуулиудад гурван үндсэн хүчин зүйл ажиглагдаж байна. Үүнд: а/ зохистой удирдлага, б/ төсөв, хандив, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний ажлын тэтгэлгээс бүрэлдсэн санхүүгийн хүрэлцээтэй нөөц, в/ чадварлаг багш нар, судалгаачид, оюутнууд /Салми 2009/. Зураг 3-д дээрхи шинж чанаруудыг бүдүүвчлэн харуулав. Энэ бүлэгт дэлхийн зэрэглэлийн их дээд сургуулиудын жишээн дээр өнөөгийн Монголын дээд боловсролын үнэлгээг хийх, чухам юуг сайжруулах талаар авч үзсэн болно.

Зураг 3. Дэлхийн түвшний их сургуулийн шинж чанар



Эх сурвалж: Салми, 2009

3.1. Засаглал

Засаглал нь тухайн байгууллага өөрийн зорилго, бодлогыг уялдаа шүтэлцээтэй, зохицуулалттай явуулах нөхцлийг бүрэлдүүлдэг. Засаглалын бүтэц нь улс орон бүрт өөр өөр байж болно. Тухайлбал, АНУ-ын хувьд бол тогтолцоо нь төвлөрлийг сааруулсан шинжтэй, төсвөөс

санхүүжих улсын их сургуулиуд болон төлөөлөн удирдах зөвлөлөөр удирдуулдаг хувийн их сургуулиуд зэрэгцэн оршдог. Английн хамтын нөхөрлөлийн орнуудын /Англи, Австрали, Энэтхэг, Панкистан гэх мэт/ боловсролын тогтолцоонд дээд боловсролыг Дээд боловсролын Комисс, эсвэл их сургууль, политехникийн Тэтгэлэгийн Комисс удирддаг. Ийм комисс нь боловсролын яамнаас хараат бус, ихэвчлэн үйлдвэрийн салбар, хувийн хэвшил, олон улсын эрдэмтдийн төлөөллөөс бүрддэг бөгөөд урт хугацааны төлөвлөгөөний үндсэн дээр хөрөнгийн хуваарилалтыг хийдэг. Боловсролын сайд нь боловсролын бодлогын асуудлаа шууд хариуцдаг улсууд ч олон байна. Аль нэг тогтолцоо нь нөгөөгөөс илүү гэх үндэслэл байхгүй бөгөөд бүгдэд нь сайн засаглалын элементүүд байдагт гол нь байгаа юм. Үүнд хууль эрх зүйн ээлтэй орчин, байгууллагын өөртөө засаглах чадвар, багш нарын судалгаа шинжилгээ эрдмийн ажил хийх эрх чөлөө, стратегийн эрхэм зорилго, манлайлал, онц чанарын төлөөх соёл зэргийг дурдаж болно /Салми, 2009/

3.1.1. Улсын сектор

Монголд, дээд боловсролын нийт байгууллагын 28 хувь нь буюу 42 сургууль нь улсын байгаа бөгөөд тэдгээрт 99,000 оюутан суралцаж байгаа нь дээд боловсролын нийт хамран сургалтын 66 хувийг эзэлж байна. Гол их сургуулиуд улсын секторт байна. Тухайлбал, Монгол улсын их сургууль /МУИС/, Шинжлэх ухаан, техникийн их сургууль /ШУТИС/, Монгол улсын боловсролын их сургууль /МУБИС/, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль /ЭМШУИС/, Хөдөө аж ахуйн их сургууль /ХААИС/ байна. МУИС нь хууль, олон улсын харилцаа, гадаад хэл, эдийн засаг, геологийн чиглэлээр хүчтэй, ШУТИС нь уул уурхай, компьютерийн шинжлэх ухааны чиглэлээр сайн хөгжсөн. Харьцангуй сүүлд байгуулагдсан сургуулиуд, тухайлбал Санхүүгийн их сургууль бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрөөрөө улсын хэмжээнд тэргүүлж байна. Улсын их сургуулиудыг нэгтгэн, арван зургаан их сургууль болгох шийдвэр гараад байна.

Монгол улсад дээд боловсролын асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам шууд хариуцдаг ба дээд боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор үйл ажиллагаа нь зохицуулагддаг. Дээд боловсролын газар нь бодлогын асуудлыг хариуцдаг. Боловсролын сайд дээд боловсролын асуудлыг бүхэлд нь хариуцдаг. Улсын их сургуулиуд БСШУЯ-ны өмнө ажлаа хариуцна.

Сайдын дэргэд зөвлөх үүрэгтэй сайдын зөвлөл ажилладаг ба гишүүдийг сайд сонгодог. Зөвлөл нь боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр өргөн хүрээтэй асуудлуудаар сайдад зөвлөгөө өгдөг бөгөөд гишүүд нь ихэвчлэн дээд боловсролын салбарын төлөөлөл байдаг. Энэхүү зөвлөл нь байнгын үйл ажиллагаагүй, шаардлагатай үед сайдын хүсэлтээр хуралддаг ба шийдвэр гаргах эрхгүй болно.

Дээд боловсролын стратеги төлөвлөлтийн асуудлыг хариуцсан албан ёсны зөвлөл эсвэл нэгж байхгүй байна. Практикаас харахад, шаардлагатай үед ажлын хэсгийг түр хугацаагаар байгуулан, гадны /голдуу Азийн хөгжлийн банкны/ санхүүжилттэйгээр ажиллуулдаг. Түр хугацаатай байгуулсан ажлын хэсэгт яамны ажиллагсад, бусад яамд болон холбогдох талуудын төлөөлөл оролцдог.

Яамны зүгээс стратегийн гол баримт бичиг болох дээд боловсролын мастер төлөвлөгөө гэх мэт бодлогын баримт бичгийг боловсруулан, Засгийн газарт өргөн барьж батлуулдаг. Зарим тохиолдолд хөгжлийн түншүүдээ урьж, тэдний санал зөвлөмжийг тусгадаг /Жишээлбэл, 2006 онд боловсруулсан Боловсролын салбарын мастер төлөвлөгөө байна/. Үйл ажиллагааны төлөвлөлтийг хийхдээ урт хугацааны стратеги төлөвлөгөөний хүрээнд яамны газар, хэлтсүүдээс боловсруулсан саналуудыг үндэслэн санхүү хөрөнгө оруулалтын газраа нэгтгэн боловсруулж, санхүүжилтийн тооцоог хийдэг. Төлөвлөгөөг сайд баталсны дараа, хариуцагч ажилтнууд хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ.

Улсын их сургуулиудын ректоруудыг яамны сайд томилдог ба харин сонгон шалгаруулалтын асуудлыг төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан төрийн албаны дэд хороо хариуцдаг. Дээд боловсролын байгууллага бүрт удирдах зөвлөл байдаг. Боловсролын тухай хууль болон дээд боловсролын тухай хуулийн дагуу, дагаж мөрдөх нийтлэг дүрэм журам, зохицуулалтыг Засгийн газраас батлан гаргадаг. Байгууллага бүр өөрийн өвөрмөц онцлогт нийцүүлэн дотоод дүрэм журмаа гаргах эрхтэй. Байгууллагын дотоод эрх мэдлийн хуваарилалтыг ректор хийдэг. Дотоод журмыг удирдах зөвлөлөөр батлах боломжтой ч практик дээр, зөвлөлийн гишүүд ректорын саналыг ихэнхдээ ямар нэг өөрчлөлтгүй, эсвэл бага зэргийн өөрчлөлттэйгээр хүлээн авч баталдаг. Улсын их сургуулиудын ректор яамны сайдтай жил бүр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулан ажилладаг ба энэ гэрээгээр дамжуулан сайдын зүгээс сургуулийн үйл ажиллагаанд зарим нөхцөл тавьж хэрэгжүүлэх боломжтой.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл /БМИҮЗ/ нь шинээр байгуулагдаж байгаа хувийн сургуулиудад магадлан итгэмжлэл хийдэг ч хамралтын түвшин ерөнхийдээ бага байна. Сүүлийн жилүүдэд, сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжилдэг болсон бөгөөд эдийн засаг, менежмент, инженерийн чиглэлийн олон хөтөлбөрүүдийг үндэсний зөвлөл болон яамны эрх олгосон тусгай нэгжүүд магадлан итгэмжилж, БМИҮЗ батламжилдаг.

Багш нарын томилгоог ректор хийдэг. Багш нарын зүгээс ёс зүйн дутагдал гаргах тохиолдолд, сургуулийн ёс зүйн хороогоор оруулан хэлэлцэж арга хэмжээ авах боломжтой. Хөдөлмөрийн хууль болон сургуулийн дотоод журмын дагуу асуудлуудыг шийдвэрлэдэг. Харин багшийн ур чадвар муу байх, заах агуулга хоцрогдсон байх тохиолдолд авах арга хэмжээ байхгүй. Хэдийгээр зарчмын хувьд байж болох боловч, БСШУЯ улсын их сургуулиудын багш нарыг халах ажиллагаанд оролцдоггүй.

3.1.2. Хувийн сектор

1991 онд Боловсролын тухай хууль батлагдснаар хувийн их дээд сургуулиуд үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрдсэн билээ. Сургуулийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад хүндрэл байхгүй, сургалтын зохих байр, тоног төхөөрөмж, багш нар, номын сан, санхүүгийн эх үүсвэртэй байх шаардлагатай. Монгол улсад дээд боловсролын эрэлт хэрэгцээ өндөр хэвээр байгаа, мөн нэмүү өртгийн болон ашгийн татвар төлдөггүй учраас хувийн коллежүүдэд хөрөнгө оруулах нь ашигтай бизнес юм. Иймээс ч 1991 онд огт байхгүй байсан хувийн их дээд сургуулийн тоо 2007 он гэхэд 144 болж өссөн бөгөөд, тэдгээрээс зөвхөн 29 нь буюу 2% нь батлан итгэмжлэгдсэн байна.

Өмчлөлийн хэлбэрээс үл хамааран бүх их дээд сургуулиудад зохицуулалтын болон хууль тогтоомж адил үйлчилдэг. Тийм учраас хувийн их дээд сургуулиуд ч гэсэн сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхдээ боловсролын стандартыг дагаж мөрдөх шаардлагатай бөгөөд дотоод үйл ажиллагаандаа яамнаас баталсан журмыг дагаж мөрдөнө. Гэхдээ улсын болон хувийн их дээд сургуулиудын хооронд нэг том ялгаа байдаг. Хувийн сургуулиудын захирлыг өмчлөгч нь томилдог бөгөөд зарим тохиолдолд өмчлөгч нь өөрөө захирлаар ажилладаг. Тэдний эрх мэдлийг хязгаарлах ямар нэг хөндлөнгийн байгууллага байхгүй.

Дээд боловсролын байгууллагууд ихээхэн өргөжсөн ч дийлэнх нь Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг тул бүс нутгийн хөгжилд төдийлэн их хувь нэмэр оруулж чадаагүй байна.

Хувийн сургуулиудын хэмжээ жижиг, нэг сургуульд дунджаар 468 оюутан ноогдож байгаа нь дээд сургууль гэхээсээ ахлах сургуулийн хэмжээтэй ойролцоо байна. АНУ болон Азийн олонх их дээд сургуулиуд 10,000-аас илүү оюутантай байдаг. Монголын дээд сургуулиудын олонх нь зөвхөн ганц мэрэгжлээр тухайлбал бизнесийн мэрэгжлээр сургалт явуулж байна. Хувийн сургуулиудад шинжлэх ухааны зэрэг дэвтэй багш нарын тоо бага. Улсын сургуулиудын багш нарын 24 хувь нь докторын зэрэгтэй байгаа бол хувийн сургуулиудад энэ үзүүлэлт 15 хувь байгаа нь хувийн сургуулиуд эрдэм шинжилгээний ажил нэг их хийдэггүйг харуулж байна. Мөн эдгээр сургуулиудын багш нарын олонх нь улсын их сургуулиудын үндсэн багшаар ажиллахын зэрэгцээ хувийн сургуулиудад цагийн багшаар ажилладаг байна. Хувийн сургуулиудад ордог хичээлийн тоо хязгаарлагдмал байдаг нь боловсролын чанарт нөлөөлж, оюутнууд өргөн хүрээтэй ерөнхий мэдлэг авч чадахгүй байгаа нь цаашлаад бүтээлч сэтгэлгээ, бие даан ур чадвараа хөгжүүлэх зэрэгт нь сөргөөр нөлөөлж болох юм.

Нөгөө талаар, улсын ба хувийн сургуулийн төгсөлтийн хувь болон төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаар үндэсний хэмжээний мэдээлэл байхгүй. Дээд боловсролын байгууллага тус бүрийн давуу тал, бэрхшээлтэй асуудлуудын талаар тодорхой баримттай мэдээлэл бодлого боловсруулагчдад байхгүй байна.

3.2. Магадлан итгэмжлэл ба чанарын батламж

Сайн засаглалд чанарын батламжийн, онц чанарын төлөө болон олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын механизмууд чухал үүрэгтэй. Магадлан итгэмжлэлийн механизм нь мэрэгжилтнүүдийн баг хөндлөнгийн үнэлгээ хийх нөхцлийг бүрдүүлдэг. Дээд боловсролын байгууллага олноор бий болж, үйлчилгээний хүрээ нь чөлөөтэй болсон болсон энэ үед боловсролын магадлан итгэмжлэл туйлын чухал үүрэгтэй. Магадлан итгэмжлэл нь чанарын батламжийн салшгүй хэсэг юм. Хөндлөнгийн байгууллага тухайн сургуулийн сургалтын үйлчилгээ, үйл ажиллагаа, эсвэл хөтөлбөрт үнэлгээ хийж, тавигдаж буй шаардлага стандартын биелэлтийг тодорхойлдог. Тавигдаж буй стандартууд биелэгдэж байгаа тохиолдолд боловсролын магадлан итгэмжлэл олгодог. Олонх улс оронд магадлан итгэмжлэлийг засгийн газрын агентлаг хариуцдаг. Харин АНУ-ын хувьд чанарын батламжийн асуудлыг засгийн газраас ангид, хувийн гишүүнчлэл бүхий нийгэмлэгүүд хариуцдаг.

Монгол улсын боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл /БМИҮЗ/ нь 1998 онд байгуулагдсан бөгөөд дээд боловсролын болон ТМБС-ын байгууллагуудад магадлан итгэмжлэл олгох асуудлыг хариуцдаг. Сургалтын байгууллагууд магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагддаг.

БМИҮЗ нь хүсэлт гаргасан байгууллагуудад магадлан итгэмжлэлийн үйлчилгээ үзүүлэн өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг. Зөвлөлийг яамны сайд толгойлдог ба бүрэлдэхүүнд нь магадлан итгэмжлэгдсэн их дээд сургууль, коллежийн захирлууд ордог. Хэдийгээр зөвлөл нь бие даасан байгууллага боловч, зөвлөлийг салбарын сайд тэргүүлдэг учраас үйл ажиллагаа нь яамны нэгжтэй адилаар байдалаар явагддаг. Нэгэнт сургуулиудын төлж байгаа төлбөрөөс хамааралтай учраас санхүүжилтийн хувьд бүрэн найдвартай бус.

БМИҮЗ-ийн бүрэлдэхүүнд Үндэсний зөвлөлийн удирдах зөвлөл, гүйцэтгэх алба, зургаан үндсэн ажилтан, дээд боловсролын магадлан итгэмжлэл хариуцсан 13 гишүүн, ТМБС-ын магадлан итгэмжлэл хариуцсан 11 зөвлөлийн гишүүн багтдаг. Зөвлөл нь хөндлөнгийн 150 үнэлээчийг түр хугацаагаар авч ажиллуулдаг. Байгуулагдсан цагаасаа хойш, зөвлөл улсын их дээд сургуулиуд, коллеж, техник мэрэгжлийн сургалтын төвүүд, хувийн дээд сургуулиудыг оролцуулаад, нийт 91 байгууллагад магадлан итгэмжлэл олгосон байна.

БМИҮЗ нь дээд боловсролын байгууллагууд, техник мэрэгжлийн сургалтын төвүүд болон тэдний үйл ажиллагаанд чанарын батламжийг олгохдоо хоёр үе шаттайгаар хэрэгжүүлдэг. Магадлан итгэмжлэлд хамрагдахыг хүссэн сургууль нь үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээ хийж зөвлөлд хүргүүлэх ба үүндээ сургалтын явц, сурган хүмүүжүүлэх практик ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг багтаадаг. Дараагийн шатанд хөндлөнгийн үнэлгээний баг тухайн сургууль дээр очиж газар дээр нь ажилладаг ба багш, оюутнуудтай ярилцлага хийх, үүрэг даалгаварын биелэлт, хичээл явуулдаг практик, ашиглаж байгаа сурах бичиг, багш нарын мэрэгжлийн ур чадвартай танилцдаг. Үнэлгээний баг сургуулиудын магадлан итгэмжлэлийг Монгол улсад мөрдөж байгаа дараах шалгууруудыг үндэслэн хийдэг. Үүнд: 1/ олон нийтэд ил тод тунхагласан тодорхой эрхэм зорилготой эсэх, 2/ энэ эрхэм зорилгодоо хүрэхийн тулд тодорхой ахиц дэвшил гаргаж байгаа эсэх, 3/ байгууллагын хөрөнгийн тодорхой хэсгийг боловсролын чиглэлд дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд зарцуулах шийдвэр гаргасан эсэх, 4/ сургууль эрхэм зорилгодоо хүрэх цогц бодлого, шийдвэр төгс байгаагаа бодитоор харуулж чадаж байгаа эсэх.

Сургалтын хөтөлбөрт магадлан итгэмжлэл олгох ажлыг 2000-аад оны эхээр эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар, үндэсний зөвлөл болон яамнаас эрх олгосон тусгай нэгж голдуу эдийн засаг, менежемент, инженерийн салбарын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлээд байна. Сургалтын хөтөлбөрт хийсэн магадлан итгэмжлэлийг БМИҮЗ батламжилна. Дээд боловсролын хөтөлбөр нь батлагдсан стандартыг хангасан байх шаардлагатай ч хэрэгжүүлэх механизм сул байна.

Магадлан итгэмжлэлд олон улсын практикт тогтсон стандартын шалгууруудыг хэрэглэдэггүй. Хөндлөнгийн үнэлгээний багд олон улсын үнэлээчид оролцдоггүй. Түүнчлэн, магадлан итгэмжлэл нь голдуу шинээр байгуулагдаж байгаа хувийн сургуулиудыг хамарч, улсын сургуулиудын хуучин болон шинэ хөтөлбөрт үнэлгээ бараг хийгдэхгүй байна. Саяхныг хүртэл, чанарын батламж болон олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын асуудал тавигдахгүй явж ирсэн. 2003 онд, дээд боловсролын тухай хуулиар аудитын шинэ хэлбэрийг нэвтрүүлсэн ба аль нэг

сургуулийн үйл ажиллагаанд аудит хийлгэх асуудлыг салбарын яам санаачилж болох бөгөөд тухайн сургууль тавигдаж байгаа шалгууруудыг хангаж байгаа эсэхийг шалгана. Магадлан итгэмжлэгдсэн хувийн дээд сургуулийн олгож байгаа зэрэг, диплом нь дээд сургуулийн хөтөлбөрийг бүрэн суралцаж төгссөний баталгаа болох ёстой.

Засгийн газрын өмнө тулгамдаж байгаа нэг чухал асуудал бол боловсролын чанарын магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх, ингэхдээ хөдөлмөрийн зах зээлтэй уялдах уялдаа холбоог сайжруулах, магадлан итгэмжлэлийн шалгууруудыг тогтоохдоо олон улсын жишиг үзүүлэлтүүдийг харгалзан авч үзэх, зайны болон гадаадын сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, мөн урамшуулал болон хариуцлагын тогтолцоог эргэн харах, оюутнуудыг сургуулиуд болон хичээлийн хөтөлбөрүүдийн чанарын талаарх бодитой мэдээллээр хангах шаардлагатай.

3.3. Санхүү

3.3.1. Боловсролд зарцуулж буй төсвийн зарлага

Төсвийн зарлагын түвшин: Өнөөгийн байдлаар Монгол улс ДНБ-ний 6-7 хувийг боловсролын салбарт зарцуулж байгаа нь хуучин социалист орнуудын түвшинтэй ойролцоо, ЭЗХАХБ-ын орнуудын дундаж 5.8 хувиас арай дээгүүр байна. Боловсролын салбарын төсвийн зарлагын энэ түвшин нь хатуу ширүүн уур амьсгалтай, өргөн уудам газарт нутагт тархан амьдардаг хүн амд боловсролын үйлчилгээг хүргэх нь өртөг өндөр байдагтай холбоотой юм.

Засгийн газрын нийт зарлагын боловсролын салбарт ноогдох хувь Зүүн Азийн орнуудын 16.2 хувьтай /Хүснэгт 7/ харьцуулахад тогтвортой өндөр явж ирсэн. Боловсролын салбарт төсвийн зарлагын хувь өндөр байгаа нь Монгол улсад боловсролын үнэлэмж өндөр байгаагийн илэрхийлэл юм. 2009 оны дэлхийн эдийн засгийн хямралын үед ч боловсролын салбарын төсвийг хасаагүй байна. Харин төсвийн нийт зарлага буурснаас боловсролын салбарт ноогдох хувь 30 хувь хүртэл өссөн дүр зураг харагдаж байна. Төсөвт эзлэх боловсролын салбарын төсөв өндөр байгаа энэ тохиолдолд дунд хугацаанд дахин нэмэгдэх магадлал багатай.

Боловсролын салбарын төсвийн хуваарилалт: Хямралаас өмнө, боловсролын салбарын нийт төсвийн зарлагын 15 хувь нь дээд боловсролд ноогдож байсан бол 2007 онд 10 хувь болон буурч, техникийн боловсрол мэрэгжлийн сургалтанд ноогдох хувь 10 хувиас 6 хувь болж буурсан байна /Хүснэгт 7/. Бага сургуульд элсэн суралцагсдын тоо нэмэгдэж, сурагч багшийн тооны харьцаа өндөр болсон. Дунд сургуульд дэвшин суралцагчдын тоо өссөн нь энэ салбарт ноогдох төсвийн хөрөнгийн хувийг өсгөхөд хүргэсэн байна. Дээд боловсролын салбарт боловсролын нийт төсвийн 10 хувь ноогдож байгаа ч нийт суралцагсдын 28 хувь нь ноогдож байна.

Хүснэгт 7. Боловсролын салбарын улсын төсвийн зарлага, 1991, 2002, 2007

	1991	2002	2007
Нэг хүнд ноогдох ДНБ /ам. доллар/, нэрлэсэн үнээр	929	1,113	1,431
Боловсролын салбарын зарлагын ДНБ-д эзлэх хувь, %	12%	8%	6.2%
Улсын төсвийн нийт зарлагад боловсролын салбарын эзлэх хувь, %	18%	16%	17%
Боловсролын зарлагын %:	-	40%	27%
- Бага	-	26%	37%
- Дунд	-	5%	6%
- Техник мэргэжил	15%	15%	10%
- Дээд боловсрол			
Нэг суралцагчид ноогдох төсвийн зардал /нэг хүнд ноогдох ДНБ-ны хувиар/			
- Бага	17%	17%	13%
- Дунд	-	14%	18%
- Техник мэргэжил	10%	5%	6%
- Дээд боловсрол	10%	12%	14%

Эх сурвалж: СЯ, БСШУЯ, Боловсролын санхүүжилтийн судалгааны баг

Боловсролын нийт төсвийн зарлагын 50 гаруй хувийг эзэлдэг бага болон дунд боловсролд Монголын нийт суралцагсдын 70 хувь ноогдож байна. Ойрын хугацаанд 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжсэнээр шинээр нэмэгдсэн ангиудыг санхүүжүүлэх, бүх нийтийг боловсролд хамруулах зорилтыг хэрэгжүүлэх санхүүжилтийг хангах нэмэлт хөрөнгийн эх үүсвэр шаардагдана. Тухайлбал, сургуульд хүүхдийг 6 наснаас элсүүлэн сургах болсонтой уялдан харьцангуй тогтвортой явж ирсэн сургуулийн өмнөх боловсролын зардалд илүү анхаарах шаардлага гарах төлөвтэй.

Дунд хугацаанд, Монгол улсын боловсролын салбарт шийдэх олон асуудлууд байна. Нэг талдаа, боловсролын зардлыг аль болохоор хамгаалан авч үлдэх шаардлагатай. Нөгөө талдаа, улс орны эдийн засгийн хөгжилд шаардлагатай байгаа өндөр ур чадвартай чанартай мэргэжилтэн, техникийн болон мэргэжлийн ажиллах хүч бэлтгэн гаргах шаардлага тулгараад байна. Нөөц боломж хязгаарлагдмал нөхцөлд, дээд сургуулиудад тэгшитгэсэн байдлаар төсвийн дэмжлэг үзүүлж, үлдсэн хэсгийг орлогоороо зардлаа нөхөх зарчмаар шийдвэрлэх замаар ерөнхий боловсролд илүүтэй хөрөнгө хуваарилах боломжийг бүрдүүлж ирсэн.

Харин цаашдаа, урт хугацаанд, эрдэс баялагийн ашиглалттай холбоотойгоор төсвийн орлогын өсөлтөөс боловсролын салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй бөгөөд түүнийг хэрхэн дээд зэргийн үр ашигтай зарцуулж, боловсролын тогтолцоог дэлхийн жишигт хүргэх вэ гэдэгт анхаарал хандуулах шаардлагатай. Үүнтэй холбогдон, боловсролын стратегийг дунд болон урт хугацаанд, нэлээд өөр хоёр өөр нөхцөл байдалд, төлөвлөх шаардлага гарч байгаа юм.

3.3.2. Дээд боловсролын санхүүжилт

Санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлэх: Монголын дээд боловсролыг ихэвчлэн сургалтын төлбөр, хандив, орлого бүрэлдүүлэх зэргээр, төсвийн бус аргаар санхүүжүүлж ирсэн /Хүснэгт 8/. ДББ-ын санхүүжилтын гол эх сурвалж нь сургалтын төлбөр болж байна. Оюутны сургалтын төлбөр хувийн сургуулиудын санхүүжилтийн бараг 62 хувийг, улсын сургуулийн

санхүүжилтийн 58 орчим хувийг бүрдүүлж байна. Төрийн сургалтын сангаас дээд боловсролын санхүүжилтийн 28 орчим хувийн тэтгэлэг, зээлийн хэлбэрээр олгож, оюутнуудын 40 орчим хувьд сургалтын зардлаа нөхөхөд нь тусалж байна. Дээд боловсролд зарцуулж байгаа нийт төсвийн зөвхөн 5 хувийг ДББ-дад шууд хуваарилдаг.

Хүснэгт 8: Дээд боловсролын байгууллагуудын санхүүжилтийн эх үүсвэрүүд, 2007 он

	Санхүүжилтийн эх үүсвэр	Бүх ДББ	Төрлөөр	
			Улсын	Хувийн
1	Улсын төсөв	5.2%	7.1%	0.3%
2	Сургалтын төрийн сан	27.6%	27.6%	21.0%
3	Сургалтын төлбөр	54.7%	54.4%	61.4%
4	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	5.8%	7.1%	1.4%
5	Хандив, тусламж	1.7%	2.1%	2.4%
6	Хөтөлбөр, төслүүд	2.9%	0.1%	8.3%
7	Бусад	2.1%	1.8%	5.4%
	БҮГД	100%	100%	100%

Эх сурвалж: БСШУЯ, 2008.

Улсын төсвөөр гол нь улсын сургуулиудын үйл ажиллагааны зардлыг, БСШУЯ-ны хөрөнгө санхүүгийн хэлтсийн хувуурилснаар, санхүүжүүлж байна. Энэ нь ихэвчлэн цахилгаан, халаалт гэх мэт урсгал зардалд явдаг бөгөөд завсар үйлчилгээнд төсвөөс хөрөнгө хуваарилдаггүй. Улсын их сургуулиудын байр сав, тоног төхөөрөмж, лаборатори зэрэгт оруулах капитал хөрөнгө оруулалтын асуудлыг захирлуудын зөвлөл шийддэг. Нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай тохиолдолд захирлуудын зөвлөл БСШУЯ-нд хүсэлтээ гаргаж, яамнаас сургуулиудын хүсэлтийг нэгтгэн, төслийг Сангийн яаманд хүргүүлж, хэлэлцдэг. Сангийн яамны саналыг Засгийн газрын хуралдаанаар оруулан хэлэлцүүлэх ба Засгийн газар эцсийн хувилбарыг УИХ-д өргөн барьдаг. УИХ-ын байнгын хороод саналыг хэлэлцэх явцад их хурлын гишүүд саналаа илэрхийлдэг. Энэ шатанд, тодорхой хөтөлбөр, төслүүдийн талаар лобби үйл ажиллагаа явагддаг. УИХ-аар төсвийг зүйл анги бүрээр баталсны дараа, засгийн газар, яам болон бусад эрх бүхий байгууллагууд хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. БСШУЯ-ны энэ хамааралт байдал, төсвийг УИХ-аар баталдаг, лоббидох үйл явцад нөлөө орох боломжтой, ДББ-ын өөрийн хөрөнгө хомс зэрэг хүчин зүлүүд нь институцийн хувьд үйл ажиллагаагаа урт хугацаанд санаачлагатай төлөвлөх, хэрэгжүүлэх үр дүнг нь бууруулж байна. Санхүүжилтийн төлөвлөлтийг богино хугацаанд /жил, жилээр/ хийдэг бөгөөд урьдчилан тооцоолох боломжгүй байдгаас дунд хугацаанд байгууллагын хөгжлийг төлөвлөх боломжгүй байна.

Дээд боловсролын нийт зарлагын 60 орчим хувийг эзэлдэг цалинг сургалтын төлбөрөөр санхүүжүүлж байна.⁴ Энэ байдал нь сургуулийн хүчин чадал, хөдөлмөрийн зах зээлд гаргаж

⁴ 2009 оны 5 сард Дэлхийн банкнаас Улаанбаатарын зургаан их сургуулийг сонгон авч төсвийн зүйл ангийн зарцуулалтыг хянаж үзэхэд их сургуулиудын нийт орлогын 55-68 хувийг ажиллагсад, багш нарын цалинд зарцуулдаг байна. Олон тохиолдолд, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг хувийн хандиваар /хоёр их сургуулийн компьютерийн лабораторийг хувийн компаниас хандивласан/ санхүүжүүлж ирсэн байна.

байгаа бүтээгдэхүүний чанараас үл хамааран элсэлтийг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Ер нь бол их дээд сургуулийн багш нарын цалин ерөнхий боловсролын сургуулийн багш нарын цалингаас нэг их өндөр биш байгаа нь өндөр чадвартай, ялангуяа чадварлаг залуу багш нарыг татаж чадахгүй байна. Хөрөнгө оруулалтын төсвийг УИХ-аар баталдаг бөгөөд улсын их сургуулиуд Засгийн газрын өмнө ажлаа хариуцдаг. Түүнчлэн, дээд боловсролын эрэлт хэрэгцээ нь нийлүүлэлтээс давж байгаа өнөөгийн нөхцөлд ДББ өөрсдийн үйлчилгээ үзүүлж байгаа оюутнуудын өмнө хариуцлага хүлээх хөшүүрэг байхгүй. Мөн өөрсдийн үйл ажиллагааны талаархи бодит мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж, тэдэнд мэрэгжлээ сонгох шийдвэрээ бодит мэдээлэл дээр үндэслэн гаргахад нь дэмжлэг үзүүлэхгүй байна.

Эрдэм шинжилгээний ажлын хувьд, хоёр төрлийн тэтгэлгийг өрсөлдөөний үндсэн дээр олгож байна. Үүний нэг нь шинжлэх ухааны академиар дамжуулан, жил бүр 16 хүртэлх тооны эрдэмтэн, судлаачдад олгодог, 4 сая төгрөг хүртэл /3600 ам. Доллар/ хэмжээний тэтгэлэг. Тэтгэлэг авч байгаа хүмүүс нь дээд түвшний онолын судалгаа хийсэн, эсвэл эрдэм шинжилгээний ажил нь практикт нэвтэрүүлэхээр зөвшөөрөгдсөн, цаашид үргэлжлүүлэх санхүүжилт шаардлагатай хүмүүс байдаг. Бусад улс оронд ийм чиглэлээр томоохон тэтгэлгүүдийг олгодог. Тухайлбал, АНУ-ын Анагаах ухааны үндэсний их сургуулийн жилийн төсөв нь 26-30 тэрбум ам. доллар байдаг ба эрдэм шинжилгээний ажлын тэтгэлэг нь хэдэн зуун сая доллар байдаг.

Хоёр дахь тэтгэлэг нь эрдэм шинжилгээний гарамгай ажил хийсэн залуу эрдэмтдэд олгодог тэтгэлэг. Жил тутмын эрдэм шинжилгээний бага хурал дээр залуу эрдэмтэд өөрсдийн хийсэн эрдэм шинжилгээний ажлын талаар илтгэл тавьдаг. Залуу эрдэмтдийн зөвлөл тэргүүний арван залуу эрдэмтдийн ажлыг салбар тус бүрээр, эрдэм шинжилгээний бага хурлын шийдвэрээр сонгон шалгаруулж, БСШУЯ-наас залуу эрдэмтдэд тэтгэлэг олгох шийдвэрийг батламжилдаг.

Их дээд сургуулиудыг үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээр нь урамшуулах, санхүүжүүлэх тогтолцоо байхгүй байна. Хугацаандаа сургуулиа төгссөн оюутны тоо, төгсөөд ажлын байртай болсон оюутны тоо, олон улсын нэр хүндтэй сэтгүүлүүдэд материал хэвлүүлсэн гэх мэт бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагааг дэмжсэн санхүүгийн хөшүүрэг үгүйлэгдэж байна. Сургалтын нөхцлийг сайжруулах, сургах болон сурах орчныг сайжруулах /лаборатори, номын сан г.м/, багш нарын мэрэгжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажил, хурал семинарт оролцоход хөрөнгө санхүүжилт хомсдолтой байгаа нь Монголын их сургуулиуд өндөр чанартай боловсрол олгоход саад тотгор болж байна.

Албан ёсны статистик мэдээгээр, улсын их сургуулиудын багш нарын 25 хувь нь цагийн багш нар байгаа нь сургалт болон эрдэм шинжилгээний ажлын чанарт ноцтой нөлөөлж байна. ДББ -ын багш нарын нийт тоонд харьцуулснаар, улсын их сургуульд докторын зэрэгтэй багш нар 16 хувь, мастерийн зэрэгтэй багш 43 орчим хувь байна. Дээрх үзүүлэлтүүд хувийн дээд сургуулиудын хувьд 5 хувь, 23 хувьтай байна. /Хавсралт 7/. Багш нарын ур чадвар, мэрэгшлийг дээшлүүлэх эсвэл олон улсын хурал семинарт оролцох санхүүжилтийг урьдчилан төлөвлөх боломж багатай, багш нарын хэвлэн нийтлүүлсэн ажил, эрдэм шинжилгээний ажлын талаар системтэй мэдээлэл байхгүй байна.

Нэг оюутанд ноогдох зардал: Өнөөдөр дээд боловсролын нэг оюутанд ноогдох төсвийн зардал /төсвөөс шууд хуваарилж байгаа зардал болон төрийн сургалтын санд хуваарилсан хөрөнгийг оруулаад/ 339 орчим ам. доллар байгаа нь олон улсын стандартаас доогуур байна.

Үүнтэй харьцуулахад, ЭЗХАХБ-ын орнуудад их дээд сургуульд суралцаж байгаа оюутанд ноогдох төсвийн зарлага 11,512 ам. доллар байна. Хятадад энэ үзүүлэлт 854 ам. доллар байдаг. Дээд боловсролын нэг оюутанд ноогдох зардлыг бага боловсролын нэг оюутны зардалтай харьцуулсан үзүүлэлт олон улсын түвшинд 6 : 1-ээс 30 : 1 гэсэн харьцаатай байдаг бол энэ үзүүлэлт Монголд 1.6 : 1 харьцаатай байгаа нь олон улсын жишгээс хэт доогуур байна. Дээд боловсролын чанар нь багш нарын мэдлэг, лаборатори, тоног төхөөрөмж, номын сан зэрэг хүчин зүйлүүдээс шууд хамааралтай бөгөөд олон улсын жишигтэй харьцуулахад Монголын нэг оюутанд ноогдох зардал туйлын бага байгаа нь чанарын хувьд ч олон улсын стандартаас доогуур байгааг илэрхийлж байна /Хүснэгт 9/.

Хүснэгт 9. Нэг оюутанд ноогдох зардлын харьцуулалт /ам. доллар/					
	СӨБ	Бага	Бүрэн бүс	Бүрэн дунд	Дээд
Монгол /2007/	-	206	285*	285	339
Хятад /2007/ төсөв	227	236	278	343	854
төсөв, хураамж, бусад	403	300	378	378	2063
ЭЗХАХБ, 2005 оны дундач	4888	6252	7437	8366	11512
АНУ	8301	9156	9899	10969	24370
Солонгос	2426	4691	5661	7765	7606
Япон	4174	6744	7630	8164	12336
Бразил 2005 **	1215	1425	2359	899	9994
Чили 2005 **	2952	1936	1865	1965	6620

Тэмдэглэл: Монголын тохиололд дунд болон ахлах сургуулийн мэдээлэл хамтдаа орсон байгаа.

3.4. Сургалтын төлбөр ба оюутны санхүүгийн тусламж

Улсын санхүүжилтээс сургалтын төлбөрөөр дамжуулан хувийн санхүүжилтэд шилжих. 1992 онд Монгол улсын Засгийн газрын 107 тоот тогтоолоор, ерөнхий боловсролын дараахь сургалтын санхүүжилтэнд шинэ журам нэвтрүүлсэн. Энэ тогтоолоор сургалтын төрийн санг бий болгож /СТС/, оюутнуудад санхүүгийн тусламж үзүүлэх асуудлыг хариуцах болсон.⁵ Санхүүжилтийн шинэ арга хэмжээ нь Зөвлөлтийн үеэс үргэлжилсээр ирсэн дээд боловсролын салбарт улсаас өгч байсан татаасны тоо, хэмжээг эрс багасгасан. Шинэ хуулиар сургуулиуд нэг оюутанд ноогдох хувьсах зардлаас хамааруулан тооцож оюутнуудаас сургалтын төлбөр авах эрхтэй болсон бөгөөд сургалтын төрийн сангийн квотын тооны хүрээнд оюутнуудад хэрэгцээнд

⁵ Сургалтын төрийн сан нь бие даасан удирдах зөвлөлтэй, гэхдээ үйл ажиллагаа нь БСШУЯ-ны харьяанд байдаг. Төрөөс үзүүлж байгаа санхүүгийн тусламжийн бүх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Удирдах зөвлөлд нь албан тушаалаараа Сангийн яам болон БСШУЯ-наас томилогддог зургаан албан хаагч байдаг. Зөвлөлд их дээд сургуулиуд болон олон нийтийн байгууллагын төлөөлөл байхгүй.

суурилсан сургалтын тэтгэлэг болон зээлийг олгож эхэлсэн ба ДББ-уудын үйл ажиллагааны тогтмол зардалд төсвөөс татаас олгох болсон.

Тэр цагаас хойш, сургалтын төрийн сангаар дамжуулан дээд боловсролын байгууллагуудыг төсвөөс дэмжсээр байна. ДББ-уудын нийт санхүүжилтэнд эзэлж байгаа хувь хэмжээ талаас нь авч үзвэл төсвөөс үзүүлж байгаа дэмжлэг харьцангуй бага хувийг эзэлдэг. СТС нь амьдралын боломж муу оюутнууд руу төдийлөн чиглэдэггүй. Сангийн дэмжлэг авсан нийт оюунуудын 39 хувь нь амьдралын боломжгүйгээс дэмжлэг авсан байхад 40 хувь нь төрийн албан хаагчийн хүүхэд гэсэн шалгуураар дэмжлэг авсан байна /Хүснэгт 10/.

Тусламжийн төрлүүд	2003		2004		2005	
	тоо	%	тоо	%	тоо	%
Хэрэгцээнд суурилсан буцалтгүй тусламж	8119	23.3	13294	33.5	13831	33.5
Эмзэг бүлгийн оюутанд үзүүлсэн буцалтгүй тусламж	2216	6.4	2454	6.2	2149	5.2
Тэргүүний оюутнуудад үзүүдсэн тэтгэмж тусламж	153	0.4	149	0.3	126	0.3
Төрийн албан хаагчийн бүлд олгосон буцалтгүй тусламж	15915	45.7	16335	41.2	16428	39.8
Зээл	8409	24.2	7390	18.6	8696	21
БҮГД	34812	100	39622	100	41230	100

Эх сурвалж: БСШУЯ, 2007

Ядуу өрхийн хүүхдүүдийн дээд боловсрол эзэмших хүсэл эрмэлзэлд сургалтын төлбөр ихээхэн саад болж байна. Монголд баклавын түвшний сургалтын нэг жилийн төлбөр нь дунджаар 383,000 төгрөг /270 ам. Доллар/ байгаа нь үндэсний нийт бүтээгдэхүүний нэг хүнд ноогдох орлогын 16 хувьтай тэнцэж байна. Энэ нь ЭЗХАХБ-ын олонх орны дунджаас дээгүүр, Өмнөд Солонгостой ойролцоо, Чили улсаас доогуур байна /Хүснэгт 11. Олон улсын хэмжээний харьцуулалт/. Хувийн сургуулиудын хувьд ч төлбөрийн түвшин дээрхтэй ойролцоо байна. Сургалтын төлбөр дээр амьжиргааны өртгийг нэмж тооцвол нэг оюутанд дунджаар 150,000 төгрөгийн нэмэлт /120 ам. доллар/ зардал шаардагдахаар байгаа юм. СТС-гаас үзүүлдэг тусламж дэмжлэг нь зардлын зарим хэсгийг, тухайлбал дунджаар сургалтын төлбөрийн 80 хувийг нөхөх боломжийг олгодог.

Хүснэгт 11. Сургалтын төлбөрийн харьцуулалт, нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүний эзлэх хувиар,

	улсын их сургууль	хувийн их сургууль
Монгол	16%	16%
Австрали	11.3%	21.9%
Канад	10.0%	-
Япон	11.8%	18.5%
Солонгос	16.3%	31.1%
Шинэ Зеланд	6.5%	-
Англи	5.2%	4.9%
АНУ	11.4%	42.0%
Итали	3.3%	11.5%
Голланд	4.4%	4.4%
Израиль	12.0%	29.2%
Чили	27.9%	32.0%

Эх сурвалж: ЭЗХАХБ боловсрол 2007, Дэлхийн банкны Дэлхийн эдийн засгийн үзүүлэлт илтгэл

Сургалтын төрийн санд хамрагдах шалгуурууд: Сургалтын төрийн сан анх байгуулагдсан цагаас хойш энэ сангийн эрх үүрэг, үйл ажиллагаанд хэд хэдэн удаа өөрчлөлт орсон.⁶ Сангийн үндсэн зорилго нь Үндсэн хуульд заасан боловсрол эзэмших эрхүүдээс үүдэлтэй. Сан нь бага орлоготой, гэхдээ сурах чадвартай оюутнуудад дээд боловсрол олох боломжийг олгохын тулд санхүүгийн тусламж үзүүлдэг. Жилд ойролцоогоор 20,000 оюутан сангаас дэмжлэг авахаар өргөдөл гаргадаг боловч хөрөнгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дунджаар 6000-7000 оюутан дэмжлэг авдаг.

Хэрэгцээнд суурилсан зээл: Энэ зээл нь хамрагдаж байгаа оюутны тоо, сургалтын төрийн сангийн хөрөнгийн хуваарилалтанд эзэлж байгаа жингээрээ гуравдугаарт орж байна. Зээл авсан оюутан арван жилийн дотор эргүүлэн төлөх үүрэгтэй. Сургууль төгссөний дараа долоо дахь жилээс эхлэн банкны арилжааны зээлийн хүүгээс 0.5 хувиар дээгүүр хүү төлөх шаардлагатай болно. Зээл авагч найман жил тасралтгүй, үүний дотор таван жил хөдөө орон нутагт ажилласан бол зээлийг эргүүлэн төлөхгүй болгодог. 2004 онд Засгийн газар төлөгдөөгүй байсан бүх зээлийг хүчингүй болгосон.


Хэрэгцээнд суурилагагүй тусламж: Буцалтгүй тусламж нь сургалтын төрийн сангийн хамгийн том хөтөлбөр юм. Төрийн албан хаагчийн хүүхэд буцалтгүй тусламж болон зээлийн аль алинд нь хамрагдах боломжтой. Төрийн албан хаагчийн нэг хүүхэд их дээд сургуульд суралцах хугацаандаа сургалтын төлбөрийн зориулалтаар буцалтгүй тусламж авдаг. Тусламжийг

⁶ 1995 онд, оюутнуудад санхүүгийн тусламж олгох шалгуур, зээлийг эргүүлэн төлөх нөхцлийн талаар шинэ журам гаргасан ба төрийн албан хаагчийн хүүхдэд санхүүгийн тусламж олгох тухай нарийвчилсан хөтөлбөр нэмж гарсан. Санхүүгийн тусламжид гадаадад магистер, докторын оюутнуудыг болон сурлагын амжилт гаргасан ЕБС төгсөгчдийг мөн хамруулахаар өргөтгөсөн. 2000 онд, 700-гоос цөөн толгой малтай малчин өрхийн нэг хүүхдэд дэмжлэг үзүүлэх, гурав буюу түүнээс дээш хүүхэд нь ДББ-д сурч байгаа бол нэг зөвхөн хүүхдэд нь тусламж олгох заалтуудыг нэмсэн /Хайрцаг 1/.

семестэрээр олгодог ба тухайн оюутны сурлагын амжилт болон эцэг эх нь төрийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж байгаа эсэхийг харгалзан үргэлжлүүлдэг.

Засгийн газрын 2000 оны 201 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн хүүхэд буцалтгүй тусламжид хамрагдах болсноор сургалтын төрийн сангийн хамралт эрс тэлсэн. /Зураг 4/. 2007 оны байдлаар, нийт дэмжлэг авагчдын 40 хувийг төрийн байгууллагад ажиллагсдын хүүхэд /17,000/ эзэлж байна /Хүснэгт 12/. Хэдийгээр сургалтын төрийн санд орлого багатай ядуу өрхийн хүүхдүүд хамрагдах нь илүү зохимжтой ч дэмжлэг авч байгаа оюутнуудын 54 орчим хувь нь ядуу бус оюутнууд байна.⁷

Зураг 4: Сургалтын төрийн санд хамрагдах шалгуурыг өргөжүүлсэн байдал



⁷ 2000 оноос хойш, сургалтын төрийн сангийн дэмжлэг авсан ядуу бус оюутнуудын тоо 13,487-оос 18,402 болон 36 хувиар өссөн байна /Сангийн ажилтантай хийсэн ярилцлага/.

Хүснэгт 12: Сургалтын төрийн сангийн хөрөнгийн хуваарилалт, 2007

	Хамрагдсан оюутны тоо	Жилд олгосон дүн, дунжаар / ам. доллар/	СТС-д эзэлж буй хувь
Буцалтгүй тусламж	17,053	222.16	39.0%
Зээл	8,007	232.25	19.2%
Төрийн албан хаагчийн хүүхдэд олгосон тусламж	6,442	246.17	16.3%
Төрийн албан хаагчийн хүүхдэд олгосон зээл	11,198	221.13	25.5%

Эх сурвалж: БСШУЯ, 2008

Хамрагдах шалгуурыг тэлсний үр дагавар: СТС-гийн хөрөнгө хязгаарлагдмал өнөөгийн нөхцөлд ядуу бус оюутнуудад тусламж үзүүлэх нь ийм тусламж авбал зохих зарим ядуу оюутнууд хасагдаж байна гэсэн үг. Ийм байдалд одоо аль хэдийн ороод байна. Хүснэгт 3-аас харахад, дээд сургууль төгсөгчдийн дунд байршлын болон орлогын бүлгүүдийн хувьд нэлээд ялгаатай дүр зураг гарч байна. Ялангуяа хөдөө орон нутагт амьдардаг болон хамгийн бага орлоготой ядуу бүлгийн хувьд тэгш бус байдал тодорхой харагдаж байна. Хурдацтай тэлж байгаа төрийн албан хаагчийн хүүхдүүдийн хувьд тэд ядуу, сурлагын онцгой амжилт гаргасан байх гэсэн давхар шалгууруудыг хангах магадлал бага.

БСШУЯ-ны СТС-гийн жилийн төсөв нь нийт суралцаж байгаа оюутнуудын 60 хувьд санхүүгийн тусламжид үзүүлэхийг зорьдог. Энэ хувийг, санхүүгийн тусламжид хамрагдах оюутнуудын сонирхлыг судалсан судалгаанд тулгуурлан гаргасан байна. БСШУЯ-наас сангийн үйл ажиллагаа нь зорилтот бүлэг буюу тусламж шаардлагатай байгаа оюутнуудад хэр хүрч байгаа, мөн оюутнуудын хэдэн хувь нь тусламж шаардлагатай ч авч чадахгүй байгаа талаар мэдээлэл гаргадаггүй байна.

Түүнчлэн, Хүснэгт 13-д үзүүлснээр, 2007 оны байдлаар олгож байгаа тусламжийн түвшин болон дээд боловсролын дундаж зардалтай харьцуулахад /амьжиргааны өртгийг оролцуулаад/ хангалтгүй байна. СТС-гаас оюутнуудын амьжиргааг дэмжих тусламж үзүүлдэггүй тул СТС-д хамрагдсан оюутнууд амьжиргааны өртгөө өөрсдөө хариуцдаг. Энэ нь ялангуяа улсын болон хувийн, өндөр өртөгтэй их дээд сургуульд суралцагсдын хувьд бүр хэцүү тусдаг. БСШУЯ-ны мэдээллээс харахад, тухайн оюутан гэртээ амьдардаг эсэхээс хамааран сургалтын төлбөр нь коллежид нэг жил суралцах нийт зардлын 13-36 хувийг эзэлж байна.

Хүснэгт 13. Коллежид суралцах нийт зардалд сургалтын зардлын эзлэх хувь

	Гэртээ амьдарч байгаа	Дотуур байранд амьдарч байгаа	Байр хөлслөн амьдарч байгаа
Нэг жилийн амьжиргааны зардал, төгрөгөөр	832,000	1,262,000	2,342,000
Сургалтын төлбөр	300,000	300	000
Сургалтын төлбөрийн эзлэх хувь	36,1	23,7	12,8

Жич: Алтанцэцэгийн мэдээлэлд үндэслэв, 2002, Дэлхийн банк, 2008

3.5. Боловсролын салбарын шинэчилсэн мастер төлөвлөгөөний стратеги

Боловсролын шинэчилсэн мастер төлөвлөгөөнд /2010/ энэхүү бодлогын баримт бичигт тодорхойлсон олон асуудлыг авч үзсэн байна. Гол стратеги нь дээд боловсролын чанар, тэгш байдлыг хангах, эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлтийн уялдаа холбоог дараахь байдлаар хангахаар тусгасан байна:

- 2017 он гэхэд, нийт дээд сургуульд суралцагчдын дотор инженер, технологи, байгалийн шинжлэл, боловсрол, ХАА-н мэрэгжлээр суралцагсдын эзлэх хувийг 32-оос 41-д хүргэж нэмэгдүүлэх, нийгэм, хууль, анагаах ухааны мэрэгжлээр суралцагсдын хувийг 30-аас 29 болгон бууруулах,
- Инженер, технологи, байгалийн шинжлэл, боловсрол, ХАА-н мэрэгжлийн чиглэлээр суралцагч 5 оюутны 3-ыг , харин бусад мэрэгжлээр суралцаж байгаа 5 оюутны 2-ыг сургалтын төрийн сангийн хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжид хамруулах ба сурлагын үр дүнгээс хамаарах тэтгэлэг нэвтрүүлэх, сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, тэтгэлгийн хооронд зохистой харьцаа тогтоох,
- МУИС, ШУТИС, МУБИС, ЭМШУИС, ХААИС-д орчин үеийн ном, сурах бичиг, сургалтын гарын авлага болон гадаад хэл дээр хэвлэгдсэн бусад материал худалдан авахад нь зориулж 25,000 ам. долларыг олгох,
- Үндэсний их сургуулиудыг номын сангуудын сүлжээнд оруулах, их сургуулийн багш, оюутан, судлаачид энэ сүлжээнд үнэ төлбөргүй чөлөөтэй нэвтрэх нөхцлөөр хангах,
- Их сургуулийн багш нарыг гадаадын тэтгэлэгт хамруулах, багш нарын мэрэгжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг дэмжих,
- Олон улсын их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх замаар их сургуулийн багш нарын чадавхийг бэхжүүлэх, ялангуяа хөдөө ажиллаж байгаа багш нарыг дэмжих,
- Дээд боловсролын байгууллагуудын чанарын баталгааны тогтолцоог хөгжүүлэх,
- Гол их сургуулиудад олон улсын стандартын шаардлага тавьж нэвтрүүлэх

- Дээд боловсролын байгууллагуудын санхүүжилт, засаглалын асуудалд цогц үнэлгээ хийх,
- Монголын дээд боловсролын мэргэжлийн хөтөлбөрүүдийн зохистой байдал, сургуулиудын магадлан итгэмжлэлийн стандартыг цогцоор нь эргэн харах.

Үүнээс гадна, 2010 онд дээд боловсролын улсын 42 байгууллагыг нэгтгэн 16 болгох шийдвэр гарсан. Дээд боловсролын чанар, нийцийг сайжруулахын тулд бүтцийн үндсэн өөрчлөлт хийх шаардлагатай байгаа бөгөөд энэ талаар Бүлэг 4-д авч үзсэн болно.

4. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД

Олон улсын туршлагаас харахад, аливаа улс орны иргэд нь өндөр боловсролтой байх нь хөгжлийг авчирдаг. Боловсрол сайтай иргэд технологийн шинэчлэл өөрчлөлтөд хялбар зохицдог, шинэ ур чадварыг хурдан эзэмшдэг бөгөөд бүтээлч ажил болон хувийн бизнес эрхлэлтээр өөрсөддөө орлого бүрдүүлэх чадвартай байдаг. Мөн, даяарчлалын эринд, өөрчлөлтийг урьдчилан тооцох боломж багатай энэ нөхцөлд, боловсролтой хүмүүс нь олон улсын хэмжээнд хөрвөх чадвартай байж, орлого нэмэгдүүлэх боломжийг өөрийн улсын хилээр хязгаарлагдахгүйгээр эрэлхийлэх боломжтой. Иймээс ажиллах хүчний хөгжлийг төлөвлөхдөө зөвхөн ажлын байрны өсөлтөөр төлөвлөх нь ирээдүйд шаардагдаж байгаа ур чадварыг бий болгоход хангалттай байж чадахгүй юм. Дээд боловсролын бодлого нь дотоодын хөдөлмөрийн зах зээл болон хөдөлмөр эрхлэлтийн албан секторын дунд хугацааны эрэлт хэрэгцээнээс цааш алсыг харсан байх ёстой. Элсэлтийг хязгаарласан бодлого байх ёсгүйн зэрэгцээ чанар, тэгш байдлыг хангах үр дүнтэй механизмыг бий болгох шаардлагатай бөгөөд дээд боловсролын байгууллагуудад онц чанарын төлөөх соёлыг хөгжүүлэх урамшууллыг бий болгох хэрэгтэй. Энэ бүлэгт, 2010 онд шинэчлэн боловсруулсан боловсролын салбарын мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн стратеги дээр нэмэлт болгон чанарыг сайжруулах талаар дөрвөн арга хэмжээ, тэгш байдлыг хангах талаар нэг арга хэмжээг санал болгож байна.

4.1. Дээд боловсролын байгууллагуудын чиг үүргийг ялгаатай болгох, тасралтгүй сургалтын тогтолцоог боловсронгуй болгох

Монголд дээд боловсролын олон янзын байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаа, мөн дээд боловсролын нийгмийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа энэ нөхцөлд улсын болон хувийн хэвшлийн боловсролын байгууллагуудын хэтийн зорилгыг ялгаатай тогтоож, янз бүрийн шатны, ялгаатай сургалтуудыг бий болгох явдал чухлаар тавигдаж байна. ЭЗХАХБ-ын орнуудад ч, хэдхэн тооны гол их сургуулиудад дэлхийн зэрэглэлийн, дээд зэргийн судлаач, эрдэмтэн профессорууд, болон оюутнууд, сурах нөхцөл, нөөцийг төвлөрүүлсэн байдаг /Хүснэгт 14/. Тухайлбал, АНУ-ын 5,000 гаруй их дээд сургуулиудын зөвхөн 30 орчим нь л эрдэм шинжилгээний ажил эрхэлдэг их сургуулиуд байна. Гэхдээ хоёрдугаар шатны их дээд сургуулиуд болон олон нийтийн коллежүүд нь дээрхээс өөр боловч ач холбогдлын хувьд мөн адил чухал, өөрийн гэсэн үүрэг хүлээж байдаг ба энэ нь олон нийтэд үйлчлэх, бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах явдал байдаг. Хайрцаг 1-д Калифорний их сургуулийн тогтолцоог жишээ болгон үзүүлсэн болно.

Хүснэгт 14. ЭЗХАХБ-ын болон бусад зарим орны дээд боловсролын гурван талт тогтолцоо

Орон	I шат	II шат	III шат
Австрали	8 эрдэм шинжилгээний их сургууль	32 шинэ их сургууль, зарим коллежүүд	68 коллеж
Хятад	36 гол их сургууль	Мужийн гол 31 их сургууль	Мужийн, хотын, хувийн 2000 их сургууль
Франц	37 их сургууль	86 их сургууль	123 их сургууль 280 салбар сургууль
Герман	78 техникийн болон их сургууль	182 их сургууль	Хос сургалттай институтууд
Өмнөд Солонгос	10 улсын их сургууль, 7 хувийн их сургууль	24 улсын их сургууль 150 хувийн их сургууль	4 улсын коллеж 144 хувийн коллеж
Мексик	10 холбооны болон төрийн их сургууль 8 хувийн их сургууль	54 улсын их сургууль 184 хувийн багшийн коллеж 249 улсын багшийн коллеж	60 техникийн их сургууль 211 техникийн дээд сургууль 995 хувийн коллеж
Англи	20 “Оксбриж”, “Рассел” их сургууль	53 их сургууль	340 тасралтгүй боловсролын коллеж
АНУ	Айви Лиги, улсын, хувийн эрдэм шинэжилгээний 690 их сургууль	политехник, коллеж ба мужийн 1760 их сургуулиуд	1075 олон нийтийн коллеж, технологийн дээд сургуулиуд

Эх сурвалж: Михаил, 2008

Эрдэм шинжилгээний, мэргэшлийн, пара-мэргэшлийн, техникийн мэргэжлийн гэх зэргээр боловсролын байгууллагын чиг үүргийг ялгавартайгаар чиглүүлж хөгжүүлэхийн зэрэгцээ өнөөгийн даяаршлын эрин үед зайлшгүй шаардлагатай амьдрах арга ухааны ур чадварыг суралцагсад эзэмшүүлэх нь мөн адил чухал гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Үүнд харилцааны соёл, аман болон бичгийн харилцааны чадвар сайтай байх, нийтлэг хэлээр чөлөөтэй ярьдаг байх /англи эсвэл бүс нутгийн хэмжээний түгээмэл хэл/, эдийн засаг, хууль, бизнесийн ерөнхий мэдлэг /банк, санхүү, нягтлан бодох, маркетинг гэх мэт/, шинжлэх ухааны анхан шатны мэдлэгтэй байх, компьютер, дэлхий нийтийн байдал, соёл зан заншлаас суралцах гэх мэт хамаарна. Хэдийгээр эдгээрийг ихэвчлэн нийгмийн ухаан болон мэргэжлийн боловсролд оруулан тооцож ирсэн уламжлалтай ч гэсэн, өнөөдрийн нөхцөлд эдгээр нь ямар ч мэргэжлээр төгсөгчдийн хувьд ирээдүйн карьерт нь чухал ач холбогдолтой.

Нэгэнт энэ төрлийн хөтөлбөрүүд нь харьцангуй өртөг багатай байдаг, мөн олон хувийн сургуулиудад энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа учраас энэ харьцангуй давуу талыг ашиглах, оюутнууд нэг сругуулиас нөгөөд шилжин суралцах боломж бүрдүүлэх замаар тогтолцоог боловсронгуй болгон, оюутнуудын ур чадварыг илүү хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хайрцаг 1. Калифорнийн их сургуулиуд ба олон нийтийн коллежийн тогтолцоо

Калифорни мужид дээд зорилго чиглэлээрээ ялгаатай боловсролын байгууллагуудын гурван шатлалт, улсын сургуулиудын тогтолцоотой. Үүнд Калифорнийн их сургууль /КИС/, Калифорни мужийн их сургууль /КМИС/, олон нийтийн коллежүүд гэсэн шатлалтай. КИС нь ахлах сургууль төгсөгчдийн топ 8%, КМИС нь ахлах сургууль төгсөгчдийн топ 33%-иас элсүүлэн авдаг бөгөөд олон нийтийн коллежүүд нь ахлах сургууль төгссөн болон ерөнхий боловсролын дипломтай эсвэл 18 насанд хүрэгчдийг элсүүлэн авах нээлттэй бодлого баримталдаг. Сургалтын зардлын хувьд олон нийтийн коллежүүд туйлын хямд. Нэг семестрийн нэг кредит нь 20 ам. доллар байдаг. Системийн хэмжээнд албан ёсны зохицуулагч байгууллага ажилладаг бөгөөд энэхүү системийн гол үндсэн чанар нь эдгээр өөр өөр шатны сургуулиуд нь уялдаа холбоотой, оюутнууд нэг сургуулиас нөгөөд нь шилжин суралцах бүрэн боломжтой байдагт оршино.

Олон нийтийн коллежүүд өргөн хүрээний сургалтын хөтөлбөрүүдтэй. Үүнд: 1/ ерөнхий мэдлэгийн 2 жилийн сургалтанд оюутнуудыг хамруулж, “үндсэн” шаардлагыг хангасан оюутнуудыг дээд боловсрол эзэмших 4 жилийн их сургуульд шилжүүлдэг, 2/ мужийн болон үндэсний хэмжээний их дээд сургуульд суралцах бэлтгэлийг хангах эсвэл ажлын талбайд гараад өндөр цалинтай байх /сувилагч, компьютер засвар, хууль хэрэгжүүлэх г.м/ чиглэлээр сертификатын сургалтыг олон тооны техник мэрэгжлээр сургалтын хөтөлбөрөөр явуулдаг, 3/ орон нутгийн үйлчилгээнүүдийн хүрээнд ажлын байр олж өгөх, насанд хүрэгчдийн боловсролын сургалтууд, орон нутгийн бизнесүүдийн захиалгат сургалтууд, сургууль завсардагчдад ахлах сургуулийн диплом олгох сургалт эсвэл ерөнхий боловсрол олгох сургалтуудыг явуулдаг, 4\ бакалаврын сургалтуудыг зохион байгуулдаг. Зарим олон нийтийн коллежүүд зарим их дээд сургуулиудтай холбогдох тусгай хөтөлбөрүүдээр сургалтаа зохион байгуулдаг.

4.2. Өрсөлдөөнд тулгуурласан санхүүжилтийг нэвтрүүлэн хөрөнгийг цөөхөн гол сургуулиудын санхүүжилтэд төвлөрүүлэх

Дэлхийн тэргүүлэх их сургуулиудын жишээнээс харахад өндөр чанартай боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай нэг хүчин зүйл нь санхүүжилт хангалттай байх явдал байдаг. Жишээ нь, Харвардын их сургуулийн хөрөнгө 37 тэрбум доллар, жилийн зарлага нь 3.2 тэрбум доллар, нэг оюутанд ноогдох жилийн зардал 105,041 доллар байна /хямралын өмнө/.

Хүснэгт 15: Дэлхийн тэргүүлэх сургуулиудын зэрэглэл, 2007

SJTU 2008 зэрэглэл	THES 2008 зэрэглэл	Их Сургуулиуд ^f	Жилийн зарлага (ам. доллар)	Оюутны тоо	Нэг оюутанд ноогдох зарлага (ам. доллар)
1	1	Харвардын Их Сургууль ^{a,b} (АНУ)	\$3,170,650,000	29,900	\$106,041.81
2	17	Станфордын Их Сургууль ^c (АНУ)	\$3,265,800,000	19,782	\$165,089.48
3	36	Калифорнийн Их Сургууль, Берклей (АНУ)	\$1,700,000,000	32,910	\$51,656.03
4	3	Кембрижийн Их Сургууль ^d (Англи)	\$1,470,940,000	25,465	\$57,763.20
5	9	Массачуситын Технологийн Их Сургууль ^m (АНУ)	\$2,207,600,000	10,220	\$216,007.83
6	5	Калифорнийн Технологийн Их Сургууль ^e (АНУ)	\$2,287,291,000	2,245	\$1,018,837.86
7	10	Колумбын Их Сургууль ^g (АНУ)	\$2,690,000,000	23,709	\$113,459.02
8	12	Принстоны Их Сургууль ^f (АНУ)	\$1,196,570,000	6,708	\$178,379.55
9	8	Чикагогийн Их Сургууль ^h (АНУ)	\$1,497,700,000	14,962	\$100,100.25
10	4	Оxfordын Их Сургууль ⁱ (Англи)	\$1,081,350,000	23,620	\$45,781.12

Эх сурвалж: Салми 2009.

Жич: SJTU stands for the ranking by Shanghai Jiaotong University of China, and THES stands for ranking by Times Higher Education Supplement.

Үүнтэй харьцуулахад, Монгол улс өөрийн хөрөнгийн хязгаарлагдмал нөөцийг дээд боловсролын олон байгууллагуудыг санхүүжүүлэхэд бага багаар тарамдуулан тарааж байна. Дээд боловсрол чанартай байсан нөхцөлд л Монгол улс нийгэмд шаардлагатай байгаа ур чадварыг хөгжүүлэх мэдлэгийн суурийг бий болгоно. Хямд үнээр чанар муутай боловсрол эзэмшүүлж байгаа одоогийн байдлыг өөрчлөхийн тулд, цөөн тооны гол сургуулиудад хөрөнгийг төвлөрүүлж, тэдгээрийн сургалтын чанарыг олон улсын стандартад хүргэхийг зорих асуудал чухлаар тавигдаж байна. Монгол улсын Засгийн газар дэлхийн хэмжээнд хүрч чадах хөтөлбөрүүдээ тодорхойлох хэрэгтэй. Монгол улсын сургуулиуд тухайлбал геологи, уул уурхай, палеонтологийн салбарт илүү хүчтэй байж болох юм.

Зарим үед тодорхой үйл явдал аль нэг салбарыг онцгой амжилтад хүргэх боломж нээгдэх тохиолдлууд байдаг. Жишээ нь, Гон Конгийн их сургууль 2003 онд CAPS-ын томуугийн тахал гарахад түүнд ихээхэн анхаарал хандуулж, биохимийн факультетийн бүх ажиллагсдаа холбогдох судалгааны ажилд татан оролцуулсан. Үүний үр дүнд, энэ вирус халдварын чиглэлээр

судалгааны дэлхийн тэргүүлэх байгууллага болж чадсан бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага дээрх өвчний тархалт гарахад энэ байгууллагатай зөвлөдөг болсон байна. Үүний нэг адилаар, энэ их сургуулийн архитектурын факультет 2008 оны Венчуны газар хөдлөлтэй холбоотой үйл ажиллагаанд оролцсоны дараа газар хөдлөлтөнд барилгын тэсвэртэй байдлыг тогтоох судалгаа явуулж эхэлснээр энэ салбарт нэр хүнд нь ихээхэн өссөн. Монголын их сургуулиуд, зохих хэмжээнд санхүүгийн дэмжлэг авч чадвал, олон улсын судлаачдын сүлжээнд холбогдож иймэрхүү нөхцөл байдал үүсэх үед цойлон гарч ирэх боломжтой юм.

Тэргүүлэх хөтөлбөр болон сургуулиудыг хөгжүүлэх үйл явцад, сургалтын байгууллагуудын харьцангуй давуу талыг илрүүлж, тэдгээрт суурилах замаар ажиллах, гэхдээ ингэж санхүүжилтийг цөөн хэдэн сургуульд илүү төвлөрүүлэхдээ өрсөлдөөний зарчмаар ажиллах нь хамгийн чухал.

Монгол улсад өрсөлдөөнт сан байгуулах асуудлыг авч үзэхдээ дээд боловсролын тогтолцоог оновчтой болгох зорилготой уялдуулан хэрэгжүүлэх хэрэгтэй. Сургуулиуд санхүүжилт авах хүсэлтээ гаргахдаа тухайн сургуулийн хөгжлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны гол гол үзүүлэлтүүд /багш нарын ур чадвар, мэрэгжил, мэргэшлийн түвшин, эрдэм шинжилгээний ажлууд болон нийтлэгдсэн материалууд, төгсөлтийн хувь, төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь, оюутнуудын шалгалтын үр дүн гэх мэт/-тэй холбоотой мэдээллийг хангах шаардлагатай. Санхүүжилт нь тоног төхөөрөмж худалдан авах, сургуулийн нөхцлийг сайжруулах, багш нарын мэрэгжлийг дээшлүүлэхэд зарцуулагдана. Мөн багш нарын цалингийн зарим хэсгийг төлөхөд ч ашиглаж болох юм. Энэ нь АНУ-ын их сургуулиудын эрдэм шинжилгээний ажилд тэтгэлэг олгодогтой ойролцоо маягаар хэрэгжиж болох бөгөөд тодорхой хэдэн жилийн хугацааны судлаачдын цалинг тэтгэлгийн хэмжээнд багтаан олгодог. Санхүүжилтийн ийм механизмыг бий болгосноор, сургуулиуд санхүүгийн хувьд тогтвортой оршин тогтнохын тулд оюутнуудыг олноор элсүүлдэг өнөөгийн байдлыг халахаас гадна, багш нар сургалт судалгааны ажилд цагаа илүүтэй зарцуулахыг хөхүүлэн дэмжих юм. Сургуулиудын оюутны сургалтын төлбөрийг нэмэлт хөрөнгө оруулалт болгон ашиглаж болно. Санхүүжилт олгох шийдвэрийг гаргахдаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд илүү сайн нийцсэн мэрэгжлийн чиглэлүүдийг харгалзан үзэх шаардлагатай. Ингэснээр, сулавтар хөтөлбөрүүд аажмаар шахагдан гарах эсвэл бусад хүчтэй хөтөлбөрүүдтэй нэгдэх боломж бүрэлдэнэ. Элсэлтийн хэмжээнд квот тавих нь зохистой арга зам биш бөгөөд гол нь өрсөлдөөнт санхүүжилтийн оновчтой механизм байх шаардлагатай. Хайрцаг 2-д сургуулийн хөгжил, онц чанарыг хангахад өрсөлдөөнт сангийн механизмыг ашиглаж байгаа олон улсын туршлагаас тайлбарлана.

Сургуулиудыг нэгтгэснээр зардал хэмнэгдэхгүй, учир нь цалингийн асуудал сургалтын төлбөрт дулдуйдсан хэвээр байх болно. Тийм учраас, өрсөлдөөнт сангаас олгох санхүүжилтээр дамжуулан багш нарын цалингийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, мөн бүс нутгийн болон үндэсний хөгжилд хувь нэмэр болохуйц эрдэм шинжилгээний бүтээл хийсэн багш нарыг урамшуулах механизмыг бий болгох шаардлагатай.

Өрсөлдөөнт сан байгуулахад тодорхой хэмжээний төсвийн зардал шаардагдах ба одоогийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх шаардлага гарна. Гэхдээ ийм механизмыг бий болгохгүйгээр хямд өртөгтэй, чанар муутай дээд боловсрол олгож байгаа өнөөгийн практикийг халахад хүндрэлтэй.

Хайрцаг 2. Өрсөлдөөнт сан нь санхүүжилтийн шинэлэг хэрэгсэл мөн.

Сүүлийн жилүүдэд олон улс орнууд ДББ-уудад хөрөнгө хуваарилахдаа шинэлэг, уян хатан өрсөлдөөнт санхүүжилтийн механизмыг ашиглаж байна. Өрсөлдөөнт сан нь салбарын олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, үр дүнд /бүтээгдэхүүнд/ суурилсан механизм юм. Энэ утгаараа, энэхүү механизм нь үр ашгийг нэмэгдүүлж, чанар, нийцийг дээшлүүлж чаддаг.

Өрсөлдөөнт сан байгуулснаар сургуулиуд стратегийн төлөвлөлт, сонголтоороо хөрөнгө оруулалтын төлөө өрсөлдөх болно. Хөндлөнгийн байгууллага өрсөлдөгч сургуулиудын боломж нөөц болон үйл ажиллагааны өмнөх жилүүдийн үр дүнг харгалзан хамгийн сайн төслийг шалгаруулах юм. Сонгон шалгаруулалтыг ил тод зорилготой, хамрагдах болон шалгаруулах тодорхой үзүүлэлтүүдэд тулгуурлан хийнэ.

Өрсөлдөөний зарчмыг нэвтрүүлж ажиллах нь хэд хэдэн давуу талтай. Үүнд: сургуулиудын үйл ажиллагааг сайжруулах хөшүүрэг болж, сургуулиуд өөрсдийн хэтийн зорилго, стратегиа тодорхой болгох болон дунд хугацааны төлөвлөлт хийдэг болоход түлхэц болохоос гадна өөрийн сургуулийн онцлог, шаардлагад нийцсэн үр дүнгийн цогц үзүүлэлтүүдийг тодорхойлох, түүнд хүрэхийг зорьж ажиллахыг дэмжинэ.

Сүүлийн үед өрсөлдөөнт сан нь уламжлалт хөрөнгө оруулалтаас эхлээд системтэй шинэчлэлийг хүртэлх өргөн хүрээний үйл ажиллагааг дэмжихэд ашиглагдах боллоо. Бангладеш, Индонезид өрсөлдөөнт сангаас тоног төхөөрөмж, номын сан, лабораториуд, техник мэрэгжлийн сургуулиудын хичээлийн байр, тэргүүлэх салбаруудад мэрэгжлийн их дээд сургуулиудын дипломын өмнөх болон дипломын дараахь хөтөлбөрүүдийг дэмжих замаар сургалтын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг байна. Чилид, засгийн газрын өрсөлдөөнт сан нь боловсролын тодорхой түвшний сургалтын бүтэц, хөтөлбөрийг шинэчлэх, нэг шатлалаас нөгөө шатлалын сургуульд кредит шилжүүлэн сурах боломжийг бий болгох, багш нарын мэрэгжил дээшлүүлэх болон нийгмийн эмзэг бүлгийн боловсролыг дэмжих зэрэг тогтолцооны өөрчлөлтийг дэмждэг.

Өрсөлдөөнт санг амжилттай ажиллуулах нэн чухал элемент нь төвийн болон институцийн чадавхи юм. Засгийн газраас санд хамрагдах шалгуур, сонгон шалгаруулах, хэрэгжүүлэх шалгууруудын талаар дүрэм журмыг боловсруулан гаргах ёстой бөгөөд институцүүдийн түвшинд дотоодын хяналт шалгалтыг үр дүнтэй хийх чадавхитай байх ёстой. Өрсөлдөөнт сан нь уян хатан, макро орчны өөрчлөлттэй уялдуулан тогтмол эргэн хянаж байхаар зохицуулагдсан байх боловч ердийн санхүүжилттай харьцуулахад урьдчилан таамаглах боломжоор хязгаарлагдмал юм. Гэхдээ, тогтолцооны өөрчлөлт шинэчлэл хийхэд нэн үр дүнтэй байдаг.

Эх сурвалж: Дэлхийн банкны тайлан илтгэлүүд

4.3. Дээд боловсролын комисс ба чанарын батламж

Дээд боловсролын стратеги хөгжлийг удирдан чиглүүлэх нэгдмэл засаглалын бүтэц байхгүй байгаагаас үүдэн тогтолцоо тархай бутархай, боловсролын чанар муу байна. Дээд боловсролын бие даасан Үндэсний Комисс байгуулах нь зүйтэй бөгөөд бүрэлдэхүүнд нь аж үйлдвэрийн салбарууд, гол мэрэгжлүүд, үндэсний болон олон улсын эрдэмтэн багш нарын төлөөллийг оролцуулснаар, асуудлыг олон өнцгөөс харах боломжтой болно. Комисс нь дээд боловсролын стратегийн хөгжлийн чиглэлийг тогтоох, чанарын батламжийн дүнгийн үндсэн дээр санхүүжилтийн хуваарилалт хийх, үндэсний мэдлэгийн чадварын тогтолцооны хөгжлийн явцыг хянах, ДББ-ууд бүс нутгийн хөгжлийг хэрхэн дэмжиж байгааг хянах үүргийг хүлээнэ. Комисс нь мөн бодлогын дүн шинжилгээ, стратегийн төлөвлөлтийн асуудлыг дэмждэг. Жишээ нь, Англид, дээд боловсролын комисс нь боловсролын стратегийн дараах таван зорилтыг тодорхойлоход дэмжлэг үзүүлдэг. Үүнд: 1/ сурах болон сургах үйл явцыг төгөлдөржүүлэх, 2/ хамрагдалт болон болон шудрага, тэгш хүртээмжийг өргөжүүлэх, 3/ ажил олгогчдын оролцоо, ур чадварыг хөхүүлэн дэмжих, 4/ эрдэм шинжилгээний ажлын чанарыг батжуулах, 5/ улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах дээд боловсролын хувь нэмрийг нэмэгдүүлэх. Эдгээр зорилтууд нь Монголын дээд боловсролын салбарт дэвшүүлээд байгаа зорилтуудтай тун төстэй юм. Хайрцаг 3-д, гурван сая хүн амтай Шинэ Зеланд улсад үндэсний зорилтуудаа ханган биелүүлэхийн тулд дээд боловсролын тогтолцоог удирдан чиглүүлэхэд Комиссыг хэрхэн ашиглаж байгаа туршлагаас танилцуулж байна.

Хайрцаг 3. Шинэ Зеландын дээд боловсролын комисс

Шинэ Зеландын Дээд Боловсролын Комиссыг /ДБК/ дээд боловсролын сайдын томилсон Комиссаруудын Зөвлөл удирддаг. Комисс нь засгийн газрын баталсан стратеги бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа дээд боловсролын сайдын өмнө хариуцдаг.

Сайд нь хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд комиссыг тодорхой үйл ажиллагаанд чиглүүлж болно. Харин тодорхой байгууллагад санхүүжилт өгөх, эс өгөх талаар ямар нэг чиглэл комисст өгч болохгүй. Комиссын Ерөнхий Гүйцэтгэх захирал нь 1989 оны Боловсролын хуулийн дагуу дээд боловсролын байгууллагуудын санхүү, үйл ажиллагааны эрсдэлд бие даасан хяналт тавьж, сайдад шууд тайлагнана.

Комиссын үндсэн үүрэг нь дээд боловсролын стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэх явдал бөгөөд дээд боловсролын санхүүжилтийн тогтолцоог ерөнхийд нь удирдан, сургуулиудын үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих, дээд боловсролын сайдад бодлогын зөвлөгөө өгөх үүрэгтэй. Комисс нь засгийн газраас дээд боловсролд хуваарилсан хөрөнгийн санг зарцуулах, салбар дундын бодлогын зөвлөлгөө өгөх, хэрэгжүүлэх, сургуулиудад холбогдох дэмжлэг үзүүлэх асуудлыг хариуцаж, үйл ажиллагаандаа Засгийн газраас дээд боловсролын асуудлаар тодорхойлсон тэргүүлэх чиглэлүүдийг удирдлага болгон ажилладаг. Үүнд: 1/ дээд боловсролын санхүүжилтийн ил тод, итгэлцлийн орчин, /2/ төгсөгчдийн эзэмшвэл зохих түвшний мэдлэг боловсрол, /3/ зохих хэмжээнд бэлтгэгдсэн, өндөр ур чадвартай ажиллах хүч. Үйл ажиллагаа явуулахдаа засгийн газрын гол агентлагуудтай, тухайлбал Боловсролын яам, Мэрэгжлийн агентлаг, Судалгаа шинжилгээ, шинжлэх ухаан, технологийн яам, түүнчлэн

боловсролын болон хувийн хэвшил, үйлдвэрлэлийн салбарын төлөөллүүдтэй хамтран ажилладаг.

Комиссаруудын зөвлөл нь засаглалыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Зөвлөлийг Дээд боловсролын сайд томилох ба зөвлөл сайдад ажлаа тайлагнана. Зөвлөл наад зах нь зургаа, гэхдээ есөөс илүүгүй гишүүдтэй байна. Одоогийн комиссаруудын зөвлөлд гүйцэтгэх захирал, орлогч захирал, багш нар болон үйлдвэрийн төлөөлөл, мөн нэг оюутан орж байна.

Эх сурвалж: Шинэ Зеландийн Дээд боловсролын комисс, <http://www.tec.govt.nz>

Шинэ Зеландын Дээд Боловсролын Комиссын 2009 оны жилийн

тайлан илтгэл <http://www.tec.govt.nz/Documents/Publications/TEC-Annual-Report-final=2009.pdf>

Дээд боловсролд ажил олгогчдын шууд оролцоог өргөжүүлэх замаар ажлын байрны эрэлт хэрэгцээ хэрхэн өөрчлөгдөж байгаа болон ажил олгогчид төгсөгчдөөс чухам юу хүлээж байгаад мониторинг хийх боломжийг бий болгодог. Үндэсний болон бүс нутгийн хэмжээнд төгсөгчдийн ажил эрхлэлт, авч байгаа цалин хөлсний талаар мэдээлэл цуглуулах замаар хөдөлмөрийн зах зээлийн талаар тогтмол, системтэй мэдээллийг бий болгох шаардлагатай. Үүний тулд сургуулиуд үйл ажиллагааны гол гол үзүүлэлтүүд, түүний дотор хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж байгаа бүтээгдхүүний /төгсөгчдийн/ талаарх мэдээллээр Комиссыг байнга хангаж байх шаардлагатай бөгөөд Комиссоос эдгээр статистик мэдээллийг хэрэглэгчдэд зориулан хэвлэн нийтэлж, сургуулиудын олон нийтийн өмнө хариуцлагатай байх нөхцлийг бүрдүүлнэ.

Комисс байгуулах ажлыг БМИҮЗ-ийг бэхжүүлэх ажилтай зэрэгцүүлэн хийх хэрэгтэй бөгөөд БМИҮЗ нь бүх их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн чанарын батлагааны асуудлыг хариуцах болно. Чанарын батламжийн явцад институт бүрийн сул болон давуу талуудыг дараах хоёр зорилгоор тодорхойлно. Нэгдүгээрт, тэдгээр институт бүрд өөрт нь мэдээлэл, зөвлөлгөө өгөх, хоёрдугаарт бодлого боловсруулагчдад дээд боловсролын тогтолцоог оновчтой болгох, бэхжүүлэхэд шаардлагатай мэдээлэл өгөх явдал юм. Мэрэгжлийн нийгэмлэгүүдийг чанарын батламж гаргах үйл явцад татан оролцуулах нэг механизм байгаа бөгөөд энэ нь сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг хэрхэн уялдуулах талаар санал зөвлөлгөө өгөх үр дүнтэй болох нь энэ механизмыг нэвтэрүүлсэн орнуудын туршлагаас харагдаж байна. Чанарын батламжийн тогтолцоог бакалавр, магистер, докторын хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх ёстой. АНУ-д мэрэгжлийн нийгэмлэгүүдийг *Тусгай болон мэрэгжлийн батлан итгэмжлэл-д* татан оролцуулсан нь амжилтад хүрсэн жишээ байна.

Чанарын батламжийн тогтолцоо нь тодорхой үр дүнг авчрах ёстой. Энэ нь хөтөлбөрүүдийг оновчтой болгох болон нэгтгэх асуудлаар Комиссын шийдвэр гаргах боломжоор хангана. Батлан итгэмжлэлийн байгууллага нь Ази, номхон далайн бүсийн чанарын батлан итгэмжлэлийн сүлжээнд оролцож, магадлан итгэмжлэлд дэлхийн жишиг үзүүлэлтүүдийг ашиглан, улмаар дэлхийн түвшний чанарын стандартад хүрэх зорилтыг тавибал зохино. Хайрцаг 4-д Сингапур улсад хувийн хэвшлийн сургуулиудын чанарыг сайжруулсан туршлагаас танилцуулна.

Хайрцаг 4. Дээд боловсролын хувийн сургуулиудын чанарыг хангах Сингапурын туршлага

Сингапурт хэмжээ болон сургалтын чанараараа ялгаатай 1000 орчим хувийн институтууд үйл ажиллагаа явуулдаг. Хамгийн том нь 10,000 гаруй оюутантай бол хамгийн жижиг нь хэдэн зуун оюутантай бөгөөд тэдгээр нь ихэвчлэн нэг чиглэлээр, тухайлбал, зочид буудлын менежмент гэх мэт, сургалт явуулдаг. Гадаадын оюутнууд, ялангуяа Азийн орнуудаас Сингапурт ирж суралцах оюутны тоо өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд тэдний дийлэнхи нь хувийн сургуулиудад суралцдаг учраас Сингапурын Засгийн газар өндөр чадвартай мэрэгжилтэн бэлтгэдэг улсынхаа нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэхээс болгоомжилж эхэлсэн. Тиймээс, дээд боловсролын хувийн сургуулиудын үйл ажиллагааг зохицуулах хууль гаргахаар бэлтгэж байгаа бөгөөд 2009 оны 9 сард батлагдах төлөвтэй байна.

Хуулиар дээд боловсролын хувийн сургуулиуд магадлан итгэмжлэлд хамрагдах шаардлага тавигдана. Чанарын хувьд эргэлзээтэй гэж тооцогдсон сургуулиудад дутагдал засах нэг жилийн хугацаа өгөх эсвэл дараагийн шатны арга хэмжээ болох сургуулийг хаах арга хэмжээ авна. Үүний дараа тухайн сургууль үйл ажиллагаагаа сэргээн явуулахын тулд дахин магадлан итгэмжлэлд орох шаардлагатай. Үйл ажиллагаа нь хэвийн сайн явж байгаа сургуулиудад таван жилийн зөвшөөрөл олгодог ба харин энэ хугацааны төгсгөлд дахин магадлан итгэмжлэлд орно. Шинээр тавигдах энэ шаардлага нь хувийн сургуулиуд үйл ажиллагаагаа сайжруулах, сургалтын чанарыг дээшлүүлэх хөшүүрэг болох юм.

Эх сурвалж: Хувийн хэвшлийн, дээд боловсролын зөвлөлийн захирал Линтэй хийсэн ярилцлага, 2009 оны 3 сарын 31.

Өнөөгийн Монголын магадлан итгэмжлэлийн тогтолцоо нь зайны болон гадны сургалтын үйл ажиллагаанд оролцдоггүй, тиймээс ч оюутнуудад дотоодын хөтөлбөрийг тэдгээр хөтөлбөрүүдтэй харьцуулан үзэх боломж олгодоггүй байна. Олон улсын хэмжээнд өсөх хандлагатай байгаа нээлттэй болон зайны сургалтын асуудлууд нь зохицуулалтын тогтолцоо сул Монгол шиг орнуудын дээд боловсролын чанарт зарим эрсдлийг дагуулж байдаг. Тиймээс үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх шаардлага чухлаар тавигдаж байгаа нь нэг талдаа шинээр гарч байгаа боломжийг ашиглах, нөгөө талдаа иргэдээ чанаргүй сургалтаас хамгаалахтай холбоотой юм.

4.4. Олон нийтийн өмнө хариуцлага хүлээх, хэрэглэгчдийг хамгаалах

ДББ-уудын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд, төгссөн оюутнуудын ажил эрхлэлтийн статистикийг жил бүр хэвлэн нийтэлдэг болох нь сургуулиуд олон нийтийн өмнө хариуцлага хүлээх болон нөгөө талдаа хэрэглэгчдийг хамгаалахад нэн чухал юм. Ингээгүй тохиолдолд, зах зээлд эрэлт хэрэгцээ бага мэрэгжил сонгосон оюутнууд ихээхэн хэмжээний мөнгө, цагаа үрэн байж тэдний эзэмшсэн мэрэгжил нь эдийн засагт орон зайгүй гэдгийг зөвхөн төгсөх

үедээ мэдэхэд хүрнэ. Тийм учраас, хөдөлмөрийн зах зээлийн талаарх дээр дурдсан мэдээллийг хангаснаар дээд боловсрол эзэмших үү эсвэл өөр сургалтад хамрагдах уу гэдэг шийдвэрийг эцэг эх болон залуучууд зохих мэдээллийн үндсэн дээр гаргах боломжийг олгоно.

Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, хөдөлмөрийн зах зээлд идэвхитэй ажиглалт хийж байдаг олон улсын /Чили, Колумби, Итали гэх мэт орнуудын/ туршлага Монголын хувьд жишээ болж болох талтай. Хайрцаг 5-д зах зээлийн ажиглалт нь оюутнууд болон тэдний эцэг эхчүүдийг ямар сургуульд элсэх, ямар мэрэгжлээр суралцах талаар шийдвэр гаргахад нь чиглүүлж өгдөг туршлагаас өгүүлнэ.

Хайрцаг 5. Итали, Чилийн хөдөлмөрийн зах зээлийн ажиглалт хийдэг туршлага

Улс орны эдийн засгийн хөгжил, өсөлтөд хувь нэмэр оруулах чадвартай иргэдийг сурган бэлтгэх дээд боловсролын туйлын зорилгын амжилтыг тодорхойлох хоёр үндсэн алхам нь мэрэгжлийн чиг баримжаа олгох ориентаци болон ажил эрхлэх боломжоор хангах явдал юм. Харин оюутнуудын сургууль завсардалт, төгсөөд ажил олж чадахгүй байх зэрэг нь дээрх зорилтонд хүрч чадахгүй байгаагийн илэрхийлэл болдог бөгөөд нийгмийн өртөг өндөртэй. Өөрөөр хэлбэл үүний ард боловсролын салбарт оруулж байгаа улсын төсвийн алдагдал, татварын алдагдал, ажилгүй иргэдийг дэмжихэд зарцуулах төсвийн хөрөнгө гэх мэт өртгүүд дагалдаж байдаг.

Мэрэгжлийн чиг баримжаа олгох болон ажил эрхлэх боломжоор хангахад тохиолдож байгаа бэрхшээлийг даван туулах зорилго бүхий шинэлэг санаачилгад Италийн АлмаЛаурен, Чилийн Футуро Лаборал хөтөлбөрүүдийг дурдаж болно. Энэ хоёр төсөл нь мэрэгжлийн чиг баримжаа олгох болон ажил эрхлэлттэй холбоотой үр дүнтэй, хялбар он-лайн мэдээллээр сонирхогч талуудыг хангах асуудлыг шийдвэрлэх зорилго тавьсан юм. Түүний дотор, ялангуяа оюутнууд болон тэдний гэр бүлийг, холбогдох мэдээллээр хангаж, сонголтоо зөв хийх боломж олгодог.

АлмаЛауреа Италийн төгсөгчдийн талаархи хамгийн өргөн хамралт бүхий мэдээллийн сантай /2007 оны 6 сарын байдлаар 50 их сургуулийн 900,000 төгсөгчдийн мэдээллийг агуулсан/ бөгөөд одоо Италийн нийт төгсөгчдийн 67%-ийн мэдээллийг цуглуулаад байна. АлмаЛауреа анх 1994 онд байгуулагдсан, Боловсролын яам, их сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын дэмжлэгтэйгээр Италийн их сургуулиудын холбоо удирдан ажиллуулдаг. Төгсөгчид болон оюутнуудад үзүүлж байгаа үйчилгээнүүдээс дурдвал, төгсөгчдийн товч мэдээлэл буюу резюмийг он-лайн байршуулах, резюмийг сайжруулах зөвлөлгөө өгөх, он-лайн байршуулсан резюмийг байнга баяжуулан шинэчлэх боломжоор хангах, ажлын байрны болон ажил олгогч байгууллагуудын талаарх мэдээллийн санд нэвтрэх боломжийг олгох, вэбсайтаар дамжуулан санал болгож байгаа ажлын байрны асуултад хариу өгөх зэрэг болно. Мөн дипломын дараахь сургалтын хөтөлбөрүүдийн талаарх холбогдох мэдээллээр сонирхогч талуудыг хангадаг.

Сургуулиуд АлмаЛауреад нэгдэн орох хөшүүрэг ихтэй. Энд орсноор оюутнуудад нь илүү өргөн боломж бий болдог, сургалтын шинэ хөтөлбөр, ориентацийн талаар бодох, дадлагажих анхны

ажил сонгох хувилбаруудыг санал болгодог. АлмаЛауреа мөн төгсөгчдийн ажлын байрны нөхцлийн талаарх мэдээллээр хангаж, докторын зэрэг горилон бичсэн дипломын ажлын нэр, сэдвийн талаарх мэдээллийг архивлан хадгалж, төгсөгчдийн талаар гаргасан тодорхойлолтыг баталгаажуулан, вэбсайтаар дамжуулан дипломын дараахь болон магистерийн сургалтыг хөхүүлэн дэмждэг.

Ажил олгогчдын хувьд бол төгсөгчдийн талаархи Италийн хамгийн том мэдээллийн санд орж сонголт хийх, резюмийг хялбар худалдан авах, шалгуурт тэнцэж байгаа хамгийн шилдэг кандидатыг сонгож авах, шинэ ажлын байрны талаар зар тавих, өөрийн компанийг сурталчлан төгсөгчдийг татах зэрэг үйлчилгээг онлайн хэлбэрээр авах бололцоотой.

Футуро Лаборал төсөл мэрэгжлийн чиг баримжаа олгох шатанд илүү анхаарал төвлөрүүлдэг. Боловсролын яамны дэмжлэгтэйгээр Адолфо Абанезийн сургууль, Чилийн үйлдвэрийн инженерийн их сургуультай хамтран байгуулсан энэ механизм нь залуучууд, оюутнуудад мэрэгжлийн чиг баримжаа олгох зорилготой. 100 гаруй мэрэгжлээр болон техник мэрэгжлийн нийт төгсөгчдийн 75 хувийн төлөөллийн ажлын байрны талаархи мэдээллээр хангадаг. Эдгээр мэрэгжил бүрийн тухайд зэх зээл дээрх цалингийн түвшин, тухайн мэрэгжил эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр болон ажил эрхлэх боломжуудын талаар мэдээлэл өгдөг.

АлмаЛаурео төслийн нэгэн адилаар, Футуро Лаборал хөтөлбөр нь энгийн, хэрэглэгчид ээлтэй байдаг. Вэбсайтаар дамжуулан, оюутнууд сонирхож байгаа мэрэгжлийн хөтөлбөрийн түвшин, чиглэлээр мэдээлэл авах, гадаадын вэбсайтуудад орж тухайн орнуудын карьер, ажлын байрны холбогдолтой мэдээлэл авах, түүнчлэн техникийн болон мэрэгжлийн төгсөгчдийн ажлын байрны тухай мэдээллийн баялаг сан бүхий онлайн номын санд нэвтрэх боломжтой юм.

Энэхүү хоёр санаачилга нь хөдөлмөрийн зах зээлийн талаар ойлголтыг сайжруулах, хувь хүмүүсийн эзэмшихээр зорьж байгаа мэрэгжил, дээд боловсрол болон ажлын байрны төлөв байдлыг уялдуулан зохицуулахад чиглэгдсэн хөдөлмөрийн зах зээлийн ажиглалтын талаар тодорхой жишээ болох юм.

Эх сурвалж: Жамил Салмига, 2010 онд энэхүү илтгэлд зориулан бичсэн

4.5. Санхүүгийн тусламжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, суурь боловсролыг сайжруулах

Хүртээмжийн тэгш байдлыг хангах нь иргэдийн ирээдүйд олох цөлин хөлсийг нэмэгдүүлэх, зах зээлд хөрвөн ажиллах боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Мэдээллээс харахад бага орлоготой болон хөдөөгийн оюутнууд дээд боловсрол эзэмших боломж бага байна. Бага орлоготой /ядуу/ залуучуудын хувьд дээд боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдахгүй байгаа нь тэдний ерөнхий боловсролын сургууль төгсөлтийн түвшин доогуур, түүнчлэн дээд боловсролын сургалтын өндөр төлбөр хийх боломжгүй байдагтай холбоотой. Хүснэгт 16-гаас харахад, бүх түвшний /бага, дунд, дээд/ сургалтыг дүүргэж байгаа төгсөлтийн хувь хөдөөгийн суралцагчдын дунд хотын суралцагсадтай харьцуулахад доогуур байна. Тэд дээд сургуульд элсэн орсон тохиолдолд ч төгсөлтийн хувь нь мөн л доогуур байна. Энэ нь эдгээр

өрхийн орлогод ноогдох санхүүгийн дарамт харьцангуй өндөр байдагтай холбоотой байх магадлалтай. Хөдөөгийн хүүхдүүд, ялангуяа хөвгүүдийн бүх шатны боловсрол эзэмшилтийн хувь доогуур байна. Ийм ялгаатай дүр зураг нэн ядуу болон чинээлэг өрхүүдийн хооронд харагдаж байна. Эдгээр тоо баримтаас харахад, дээд боловсролын тогтолцооны шинэчлэл хийн хүртээмжийг сайжруулахын зэрэгцээ хүн амын бүх бүлгийн хүүхдүүд ерөнхий боловсролын сургуулиа амжилттай төгсөх боломжийг нэмэгдүүлэх чиглэлд мөн хүчин чармайлт гаргах шаардлагатай нь харагдаж байна.

Хүснэгт 16. Байршлын болон орлогын ялгаатай байдал нь боловсрол эзэмшилтийн байдалд нөлөөлж байгаа байдал

/бага ангид элсэн орогчдоос дараагийн шатны сургалтын төгсөгчдийн хувь/

	8-25 нас						
	Бүгд	Хот	Хөдөө	Хөв- гүүд	охид	Нэн ядуу	Баян
Бага	93.95	96.74	89.36	91.69	96.13	90.83	96.60
Бүрэн бус дунд	81.04	87.41	70.00	75.98	85.72	72.93	90.61
Бүрэн дунд	54.87	60.01	45.73	48.73	60.35	42.59	69.93
Дипломын сургалт	41.91	47.20	31.56	38.31	45.49	39.59	51.47
Их сургууль	9.43	10.38	7.79	10.36	9.20	7.48	12.60

Эх сурвалж: Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2006, “Монгол улс: Ололтуудыг бататган, өсөл ба уналтыг удирдаж, үйлчилгээг илүү сайн хүргэх нь” Дэлхийн банк 2008, тайланд иш татснаас авав.

Жич: Каплан Миелерийн хийсэн энэ тооцоонд, судалгаа хийж байх үед суралцаж байсан хүнийг тухайн шатны сургалтын төгсөлтийн хувь тооцоход оруулан тооцсон.

Тэгш байдлыг хангахын тулд, СТС-г мөн шинэчлэх шаардлагатай. СТС –гийн зээлийн эргэн төлөлт дөнгөж 2 хувьтай байгаа болон засгийн газар үе үе зээлийг хүчингүй болгодог тул СТС-г урт хугацаанд тогтвортой ажиллуулах, өргөжүүлэхийн тулд хөрөнгийн нэмэлт эх үүсвэр босгох шаардлагатай. Магадгүй хувийн хэвшлээс ч босгож болох юм. Үүнийг хийх нэг боломж нь арилжааны банкуудын тусламжтайгаар хийх явдал байж магад. Хэдийгээр засгийн газар цаашид ч зээл олгож, хүүгийн татаас хөнгөлөлт үзүүлж болох ч үүний зэрэгцээ арилжааны банкуудын зээлийг илүү хүртээмжтэй болгох нь зүйтэй. Ингэснээр засгийн газраас энэ зориулалтаар зарцуулж байгаа ихээхэн хэмжээний хөрөнгө нөөцийг хэмнэж, түүнийгээ одоогийн эсвэл шинээр бий болгох хэрэгцээнд суурилсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт хуваарилж болох юм.

Түүнчлэн, СТС-гийн дэмжлэг зорилтот бүлэгтээ хэр оновчтой хүрч байгааг араас нь хянадаг механизм байхгүй байгаа учраас мониторинг ба үнэлгээний илүү сайн тогтолцоо шаардлагатай байна. Зохистой арга зүйд тулгуурлан, тухайн оюутанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлага хэрэгцээ байгаа эсэхийг тодорхойлох нарийвчилсан аргачлал боловсруулж

хэрэгжүүлэх нь төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг илүү шудрага, хүртээмжтэй болгоход туслана. Ийм аргачлал нь өрхийн орлогыг зөв тогтоохоос гадна оюутнуудын сургалтын зардалд өрхөөс зарцуулах шаардлагатай хөрөнгө нөөцийг бодитой тогтоох арга зүйг багтаасан байвал зохино. Өрхийн орлогыг тооцоход зөвхөн мөнгөн орлого төдийгүй өрхийн эдийн засгийн бусад үйл ажиллагаанаас, тухайлбал мал аж ахуйгаас орох орлогыг оролцуулан тооцох шаардлагатай. /Дэлхийн банк, 2008/

5. ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ БА МЭРЭГЖЛИЙН СУРГАЛТ:

ДЭЭД БОЛОВСРОЛЫГ ОРЛОХ НЭГ ХУВИЛБАР БАЙЖ БОЛОХ УУ?

Мэрэгжлийн янз бүрийн чиглэлүүд болон дэд салбаруудын хооронд шилжин суралцах боломжтой, уян хатан боловсролын системийг бий болгохын тулд мэрэгжлийн сургалтын байгууллагууд болон энэ чиглэлийн сургалтын хөтөлбөрүүдийг /дунд сургуулийн болон дунд сургуулийн дараагийн шатанд/ өргөтгөх, багш бэлдэх коллеж сургуулиуд, олон нийтийн коллежүүдийг болон цөөн тооны судалгаа шинжилгээний байгууллагуудыг өргөтгөх шаардлагатай. Энэ бүлэгт залуучуудын мэрэгжлийн ур чадварыг хөгжүүлэх, ажлын байр бий болгох боломжийг өргөтгөх асуудлыг авч үзнэ.

5.1. Монголын ТБМС-ын тогтолцооны бүтэц ба үр дүн

ТБМС-ууд нь БСШУЯ болон НХХЯ-ны чиг үүргийн хүрээнд хамрагддаг. БСШУЯ албан ёсны, урт хугацааны /2 жил ба түүнээс дээш хугацааны/ ТБМС-ын асуудлыг, харин НХХЯ албан бус, богино хугацааны /хоёр долоо хоногоос 45 хоногийн / ТБМС-ын асуудлыг хариуцдаг. Анхан шатны мэрэгжлийн боловсрол олгодог бүх сургуулиудад 9 дүгээр анги төгссөн суралцагсдыг элсүүлэн авдаг бол түүнээс дээд түвшний мэрэгжлийн боловсролын сургуульд 11 дүгээр анги төгсөгчдийг элсүүлэн авдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 17-д үзүүлэв.

Хүснэгт 17. Монголын ТБМС-ын гол үзүүлэлтүүд

Нийт оюутны тоо	37867
-үүнээс эмэгтэй	17844
Нийт төгсөгчдийн тоо	
- 2008	8745
- 2009	11408
Нийт сургуулийн тоо	70
Үүнээс:	
- мэрэгжлийн анхан шатны сургалттай, улсын сургууль	23
- мэрэгжлийн дунд шатны сургалттай, улсын сургууль	3
- мэрэгжлийн анхан шатны сургалттай, хувийн сургууль	9
- мэрэгжлийн анхан болон дунд шатны сургалттай, техникийн сургууль, улсын	11
- мэрэгжлийн болон техникийн дээд сургууль, хувийн	6

Эх сурвалж: БСШУЯ, 2009

Албан бус, богино хугацааны мэргэжлийн сургалтын хүрээнд, Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний Газар нь хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг зохицуулдаг бөгөөд 1200 байгууллагад албан бус, богино хугацааны мэргэжлийн сургалт явуулах эрхийг олгоод байна. Эдгээр 1200 сургалт эрхлэгчдийн 150 нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр ажилгүй иргэдэд сургалт явуулж байна. Богино хугацааны ийм сургалтуудын гол зорилго нь ажилгүй иргэд шинэ мэргэшил эзэмшин, ажил эрхлэх боломжоо нэмэгдүүлэхийг нь дэмжих явдал байдаг.

Техникийн мэргэшлийг Монголд доогуурт үздэг, мөн дээд боловсрол эзэмших нь нэр хүндтэй ажил эрхлэх цаашдын замыг нээдэг гэсэн ойлголт түгээмэл байдаг нь дээд боловсролыг техник мэргэжлийн боловсролоос илүү дээгүүрт тавихад хүргэдэг. Хэдийгээр худалдааны салбарын болон техникийн ажлын байр нэмэгдэж байгаа ч дээрх байдал хэвээр байна. Монголд 140,000 орчим /Монголын хөдөлмөрлөх хүчний 15 хувьтай тэнцэх тооны/ оюутан их дээд сургуульд сурч байгаа бөгөөд тэдний олонх нь сургуулиа төгссөний дараа ажил олоход бэрхшээлтэй учирч байгаа нь сургуулиудаар бэлтгэж байгаа мэргэжлүүд болон зах зээлийн эрэлт хэрэгцээ хоорондын уялдаагүй байдалтай холбоотой юм. 2006 оны нийт төгсөгчдийн 7100 нь буюу /5.4 хувь/ нь ТБМС төгсөгчид байсан ба тэдний 48 хувь нь эмэгтэйчүүд байсан.

Оюутан суралцагсдын нэлээд хэсгийг ТБМС руу чиглүүлэх нь зах зээл ба мэргэжлийн уялдаа болон хөдөлмөрийн зах зээлийн үр дүнг сайжруулах нэг арга зам байж болох талтай. Гэхдээ бодлогын энэ хувилбар нь боловсролын чанар өндөр, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх тохиолдолд л үр дүнтэй хувилбар байж чадах бөгөөд үүний тулд өнөөгийн тогтолцоог шинэчлэн өөрчлөх шаардлагатай. ТБМС-ын чанар өндөр байх тохиолдолд л төгсөгчид нь ажил олох боломжтой.

Хэдийгээр ажил олгогчдын хувьд техник мэргэжлийн сургууль төгсөгчдийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа ч гэсэн ТБМС-д төрөөс хийх хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байсаар байна. ТБМС-ын барилга сав, тоног төхөөрөмж нь хуучирч эвдэрч муудснаас гадна ба хувийн хэвшлийн оролцоо бага байна. Өнөөгийн байдлаар хувийн хэвшлийн сургалтын байгууллагууд нь сургалтын хөтөлбөр, кредит, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг хэрэгжүүлэх зохицуулалт, хяналтын системийн гадна байна.

5.2. Монголын ТБМС-ын тогтолцооны чанарын асуудлаар тулгарч байгаа асуудлууд

Засаглал. Албан ба албан бус ТБМС-ын аль алины хувьд Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжил-арга зүйн төв /МБСМАЗТ/ нь мэргэжлийн ур чадварын стандарт, киррикулим, сурах бичиг боловсруулах, ТБМС-ын багш нар болон үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш нарыг сургалтын модуль материал бэлтгэх чиглэлээр болон заах арга зүйн чиглэлээр сургах, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа болон ТБМС-тай холбоотой бусад асуудлаар судалгааны ажил хийх үүрэг хүлээдэг. Энэ төв нь БСШУЯ-ны харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд үндсэн таван ажилтантайгаас гадна тус бүр хоёр ажилтантай зургаан бүсийн төвтэй. Түүнчлэн, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл /БМИҮЗ/⁸ ТБМС-ын хөтөлбөрт

⁸ БМИҮЗ өнөөгийн байдлаар ТБМС –ын 11 сургуулийг магадлан итгэмжлээд байна.

магадлан итгэмжлэл олгодог. Гэхдээ, энэ зөвлөл нь одоогоор техникийн боловсрол, мэргэжлийн сургуулиудын дөнгөж 10 хүрэхгүй хувийг магадлан итгэмжлээд байна.

ТМБС засаглалын хувьд тархай бутархай байна. Өнөөгийн тогтолцоонд өөр өөрийн чиг үүрэгтэй оролцож байгаа олон янзын агентлагуудын ажил хоорондоо уялдаагүй, нэгдсэн зохицуулалтгүй байна. Жишээ нь МБСМАЗТ мэргэжлийн ур чадварын 70 стандарт боловсруулсан байхад боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл эдгээрийг магадлан итгэмжлэлдээ ашигладаггүй байна. Үүнээс гадна, тоног төхөөрөмж хуучирч шаардлага хангахгүй болсон, багш нарын ур чадвараа дээшлүүлэх боломж бага зэргээс харахад нэгэнт боловсруулсан стандарт, кирриколимыг бүх сургуулийн түвшинд бүрэн нэвтрүүлж чадаагүй байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

Цаашилбал, өнөөгийн байдлаар багш бэлтгэх, ажил дээр гарсных нь дараа арга зүйн хувьд давтан сургах болон техникийн ур чадварын сургалт явуулах тогтвортой тогтолцоо, уялдаа дутагдалтай байна. Багш нарын арга зүйн сургалтыг бүхэлд нь сургуулиудын санаачилгад даатган үлдээж байна. Зарим сургууль багш нарынхаа техникийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тогтмол сургалтад хамруулдаг. Гэхдээ, ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцэх орчин үеийн техник хэрэгсэл хангалтгүй байгаа нөхцөлд шинэ техник хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй болсон цагт л багш нарын техникийн ур чадварын сургалтанд бодитой ахиц гарна.

Бодлогын түвшинд, хэдийгээр үйлдвэрийн газруудтай хамтран ажиллаж байгаа ч гэсэн оюутны дадлагын хугацаа тун богино, 30-45 хоногоор хязгаарлагдаж байна. Дээрх хугацаанаас урт хугацаагаар дадлага хийлгэх асуудал нь сургуулийн захирлын үзэмжийн асуудал байдаг бөгөөд өнөөгийн байдлаар БСШУЯ-наас үйлдвэрлэгчид болон ажил олгогчидтай илүү ойр хамтран ажиллах тал дээр төдийлөн санаачилга гаргахгүй байна.

Нөөцийн үр дүнгүй ашиглалт ба хуучирсан тоног төхөөрөмж. Боловсролын салбарын улсын төсвийн 6 хувь ТМБС-танд ноогдож байна. ТМБС-д ирж байгаа нийт төсвийн 45 орчим хувийг оюутны тэтгэлэгд зориулж, нэг хүрэхгүй хувийг дэд бүтцийн хөгжил, сургалтын төхөөрөмж авахад зарцуулж байгаа нь туйлын хангалтгүй байна.

Дийлэнхи ТМБС-ын дэд бүтцийг засварлан сэргээх, өргөжүүлэх шаардлагатай байна. Сургуулиудын захиралуудтай хийсэн ярилцлагаас харахад, олонхи сургуулийн өнөөгийн дадлага сургалтын төхөөрөмж, дэд бүтэц нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд суурилсан, ур чадварыг хөгжүүлэх хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй байна. Ихэнхи сургуулийн хувьд, дадлагын хичээлийн тоног төхөөрөмж, машин хэрэгсэл хуучирсан, эвдэрсэн эсвэл хүрэлцээгүй байгаагаас дадлагын сургалт хийх шаардлага хангахгүй байна. Олон сургууль өнөөдөр социализмын үеийн тоног төхөөрөмжийг ашигласаар байна. ТМБС-ын оюутнуудад тэтгэлэг олгох болсноор хамралтын түвшин эрс нэмэгдэж, одоогийн байгаа сургалтын нөхцөл, дэд бүтцэд нэмэлт ачааллыг бий болгосон. Зарим нэг хөгжлийн түншүүдээс хандив болгосон орчин үеийн тоног төхөөрөмж үнэхээр хэрэг болж байгаа ч тоо хэмжээний хувьд цөөн, анги дүүргэлт өндөр байгаа нөхцөлд хүрэлцээгүй байна.

5.3. Чанар ба нийцийг сайжруулах хувилбарууд

Тогтолцоог хянаж үзэх. ТМБС дэд салбарын чанар, нийцийг сайжруулахын тулд юуны өмнө засгийн газар одоогийн тогтолцоог бүхэлд нь үнэлж, юу нь болж, юу нь болохгүй байгааг тодорхойлох нь зүйтэй. ТМБС-ын тогтолцооны нарийвчилсан дүн шинжилгээг нэн даруй хийж, тогтолцоонд тууштай шинэчлэл хийх стратегийн зөвлөмжийг гаргаж ирэх шаардлагатай. Одоогийн байгаа аргачлал, киррикулим материалыг хянаж үнэлснээр заар арга зүй болон сургалтын материалуудыг сургуулиудад нэвтрүүлэх, мөн сурах бичгүүдийг хэвлэх арга замыг боловсронгуй болгох, МБСМАЗТ-ийн ажиллагсдыг тогтвортой ажиллуулах замаар ТМБС-ын шинэ агентлагын ажлын залгамж чанарыг хадгална.

Засаглал. МБСМАЗТ-ийн үүргийг ТМБС-ын шинэ агентлагийн бүтцэд багтаан, давхардлыг арилгах боломжтой. Эдийн засгийн хэрэгцээ шаардлагад зохицуулан кирриклиумыг шинэчлэн боловсруулах шаардлагыг анхааралдаа авч, киррикулим боловсруулах мэрэгжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, шинэ хүмүүсийг сонгон шалгаруулж сургах хэрэгтэй байна. Киррикулим боловсруулах ажил нь ТМБС-ын шинэчилсэн тогтолцооны амжилтад нэн чухал үүрэг гүйцэтгэх тул хэрэв шинээр санал болгож байгаа ТМБС-ын агентлагын бүтцэд⁹ киррикулим боловсруулахад шаардлагатай хүний нөөцийн хүчин зүйлийг тусгах боломжгүй бол шинэ агентлагт энэ үүргийг хариуцуулах шаардлагагүй бөгөөд харин дээрх хоёр байгууллагын хоорондын уялдаа холбоог онцгой анхаарах хэрэгтэй.

Дэд бүтэц, сургалтын тоног төхөөрөмж. Тоног төхөөрөмжийг шинэчлэх, дадлагын хичээл хийх газруудыг бий болгоход хөрөнгө нөөцийг чиглүүлэх хэрэгтэй байна. Сургалтын тоног төхөөрөмж нь зөвхөн сургалтын шинэчилсэн киррикулим материалын шаардлагыг хангаад зогсохгүй үйлдвэрийн газруудад ашиглаж байгаа техникийн стандарт, тодорхой нөхцөл шаардлагуудыг хангасан байх шаардлагатай. Дадлагын ажлын байрны стандартуудыг тогтоож мөрдүүлэх нь чухал ач холбогдолтой. Дадлагын ажлын байранд шаардлагатай тоног төхөөрөмжийг байрлуулахдаа норм нормативыг тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, төрөл бүрээр дагаж мөрдөх хэрэгтэйгээс гадна ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг дагаж мөрдөх хэрэгтэй. Нэгэнт төрөөс эхний шатанд шаардлагатай бүх тоног төхөөрөмжийг худалдан авч нийлүүлэх боломжгүй учраас харьцангуй хямд үнэтэйг нь бодолцож сургалтын зориулалтаар хийсэн дууриамал тоног төхөөрөмжийг худалдан авах нэг хувилбар байж болох юм. Үүнээс гадна, дагалдан сургах тогтолцоог сонирхсон үйлдвэрийн газруудтай түншлэн нэвтрүүлж болох бөгөөд оюутнууд дадлагын хичээлийг үйлдвэрийн туршлагатай ажиллагсадын удирдлагын дор, тодорхой өдрүүдэд ажлын байран дээр нь хийж болох юм.

Киррикулим боловсруулах ба засаглал. Баримтлах гол аргачлал нь эрэлт хэрэгцээнд нийцсэн, чадварт суурилсан байх хэрэгтэй. Энэ аргачлалыг Австрали, Сингапур /Хайрцаг 6/, Англи, Канад, Шинэ Зеланд зэрэг олон оронд өргөн хэрэглэж байна. Ажил олгогчдын талд эрэлт хэрэгцээ ихтэй байгаа чиглэлээр сургалт явуулах хичээлийн хөтөлбөр нь тухайн мэрэгжлийн хувьд үйлдвэр дээр дадлагажигчдийн ур чадвар, мэдлэгт тавигддаг шаардлагуудыг удирдлага болгох ёстой.

⁹ Дэлхийн санхүүгийн хямралтай энэ нөхцөлд ТМБС-н шинэ агентлагын бүтэц нь 20 орчим ажиллагсадтай байж болох юм.

Хайрцаг 6. Сингапурын Техникийн боловсролын институтын киррикулим боловсруулах загвар

Техникийн боловсролын институт /ТБИ/ нь сургалтын гол хөтөлбөрүүдээ төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэхдээ гадагшаа чиглэсэн, албажуулсан, 5 шатлалт үйл явцын аргачлалыг ашигладаг. Үүнд аливаа мэрэгжлийн курсыг төлөвлөх, сургалтын хэрэгцээг тодорхойлохдоо тухайн мэрэгжлийн, хөндлөнгийн зөвлөхүүдтэй өргөн хэмжээнд зөвлөлдсний дүнд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх үйл явц эхэлдэг.

Киррикулим боловсруулах үйл явц сургалтын хэрэгцээнд дүн шинжилгээ хийхээс эхэлнэ. ТБИ нь эдийн засагт дутагдаж байгаа мэрэгжлийн сургалтын хэрэгцээг олж тогтоох системтэй бөгөөд шаардлагатай байгаа орон зайг нөхөх боломжийг төгсөгчид болон ажиллагсдад олгоход чиглэсэн курсуудыг бий болгодог. ТБИ-ийн сургалтын урт хугацааны төлөвлөлт нь Засгийн газрын эдийн засгийн бодлого, санаачлагуудад тулгуурлана. Ажиллах хүчний асуудал эрхэлсэн яам болон засгийн газрын бусад холбогдох байгууллагууд, Эдийн засгийн хөгжлийн зөвлөл, Мэдээлэл холбоо харилцааны хөгжлийн газар зэрэг агентлагуудын гаргадаг ажиллах хүчний эрэлт хэрэгцээний төлөвлөлтүүд нь ТБИ-ийн хичээлийн хөтөлбөрт чухам ямар хичээлүүдийг оруулахыг шийдэх гол хүчин зүйл болдог. Эрэлт хэрэгцээний талаарх байнгын мэдээлэл, ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн сонирхол, ТБИ дээр одоо зааж байгаа курсуудын хөдөлмөрийн зах зээл дээр гаргаж буй үр дүнгийн үнэлгээ зэргийг цогцоор авч үзсэний үндсэн дээр тухайн жилийн элсэлтийн тоог тогтоодог.

Заах курсуудыг тодорхойлж баталсны дараа, 5 үе шат бүхий системийн дагуу хичээлийн хөтөлбөрийг боловсруулна. Үүнд:

Дүн шинжилгээний шатанд, тухайн сургалтын эрэлт хэрэгцээ, тухайн мэрэгжлээр ажиллахад шаардагдах мэдлэг, хандлага, ур чадвар, ажлын байранд шаардагдах ур чадварын стандартыг тогтооно. Энэ шатанд, тухайн мэрэгжлээр ажиллаж байгаа туршлагатай хүмүүсийг урьж, киррикулим боловсруулж буй ажлын хэсгийн мэрэгжилтнүүдэд мэдээлэл зөвөлгөө өгүүлдэг.

Хөтөлбөрийн бүтцийг тодорхойлох шатанд, сургалтын хөтөлбөрийн агуулга, дизайныг тодорхойлно. Элсэлтийн шаардлага болон хичээлүүдийн зорилгуудыг нарийвчлан тодорхойлж, оюутнуудыг үнэлэх шалгах чиглэлийг тодотгоно. Түүнчлэн сургалтын ямар нөхцөл бүрдүүлэх, ажиллагсдыг хэрхэн сургаж бэлдэхийг төлөвлөнө.

Боловсруулах шатанд, багш нар болон оюутнуудын ашиглах сургалтын материалуудыг боловсруулна. Эдгээр материалд, багшийн ашиглах тэмдэглэлүүд, дадлага ажлын зааварчилгаа, дүрс дуу бичлэгийн материалууд, компьютерт суурилсан сургалтын багцууд орно.

Хэрэгжүүлэх шатанд хөтөлбөрийг эхлээд туршилтын хэлбэрээр хэрэгжүүлж, явцад нь хяналт тавина. Хөтөлбөрийг үнэлж, доголдолтой зүйлүүдийг илрүүлэн, киррикулим материалууд болон заах арга зүйн тогтолцоог засаж залруулах ажлуудыг хийнэ.

Эцэст нь, үнэлгээний шатанд, сургалтын хөтөлбөр дэвшүүлсэн зорилгодоо хүрч чадсан эсэхийг үнэлж дүгнэнэ. Ингэхдээ оюутнууд сурах ёстой зүйлээ сурч чадсан уу, ажил олгогчдын хүсэн

хүлээж байгаа хэмжээнд ажил үүргээ гүйцэтгэх чадвартай болж чадсан уу гэдэг талаас нь үнэлэлт дүгнэлт өгнө.

Эх сурвалж: Сингапурын Техникийн боловсролын институт

Багш бэлтгэх, давтан сургах, сонгон шалгаруулалт. Багш нарыг авч ажиллуулах, сонгон шалгаруулах асуудлын хувьд ТМБС-ын шинэ агентлаг нь багш нарт тавигдах наад захын шаардлагыг тодорхойлон гаргаж болох юм. /Хайрцаг 7, Данийн загвар/ ТМБС-ын багш нарын техникийн чадвар нь заах гэж байгаа түвшнээсээ нэг шат өндөр байх шаардлагатай бөгөөд тухайн чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан туршлагатай, заах арга зүйн сургалтад хамрагдсан байх шаардлагатай. ТМБС-ын бүх багш нар бакалаварын зэрэгтэй байх шаардлагагүй, учир нь энэ зэрэг нь мэдлэгт илүү, харин ур чадварт бага төвлөрсөн байдаг. Тиймээс багш нарыг сонгон шалгаруулж ажилд авах тогтолцоо нь бакалаварын зэрэггүй ч гэсэн өндөр ур чадвартай техникийн ажилтнуудыг сонгож болохоор уян хантан байх шаардлагатай. Түүнчлэн, одоо ажиллаж байгаа байгаа нарыг заах аргын сургалтанд ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр хамруулж, сургуулийн амралтын хугацаанд үйлдвэрийн газарт түншүүдтэй хамтран ажиллах замаар үйлдвэрлэлийн талаархи мэдлэгээ дээшлүүлэх боломжийг бий болгоно. Шинээр ажилд орж байгаа багш нарыг заах арга зүй болон техникийн ур чадварын сургалтад хамруулах ёстой. ТМБС сургуулиуд нь үйлдвэр дээр ажиллаж байгаа мэрэгжилтнүүдийг цагийн багшаар авч ажиллуулахыг хөхүүлэн дэмжих хэрэгтэй.

Хайрцаг 7: Дани улсын ТМБС-ын багш нарт тавигдах шаардлага ба сургалт

Дани улсад мэрэгжлийн боловсролын сургалтын багш нар нь тухайн заах гэж байгаа чиглэлээрээ мэрэгжлийн боловсрол эзэмшсэн байхаас гадна түүн дээрээ нэмээд дээд боловсрол эзэмшсэн байдаг. Таваас доошгүй жилийн мэрэгжлийн туршлагатай байх шаардлага тавигддаг. Харин ерөнхий мэдлэгийн багш нарт бол хоёроос доошгүй жил ажилласан байх шаардлага тавьдаг. Ерөнхий мэдлэгийн хичээл зааж байгаа багш нар нь бакалавар болон магистерийн зэрэгтэй байдаг.

Заах аргын сургалтад хамрагдаагүй багш нар техник мэрэгжлийн коллежийн багш нарт зориулсан заах аргын курсад заавал хамрагдах шаардлагатай. Коллежид багшилж эхэлсэн эхний хоёр жилийн хугацаанд энэ сургалтыг дүүргэсэн байх ёстой.

Багш нар өөрсдийн онолын болон заах аргын мэдлэгээ байнга дээшлүүлж, цаг үеэсээ хоцрохгүй байх үүрэгтэй. Коллежийн захиргаа нь багш нарынхаа мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөө гарган ажилладаг.

Эх сурвалж: www.eng.uvm.dk.

ТМБС-ын санхүүжилтийг сайжруулах. Монгол улсын хувьд улсын болон хувийн хэвшлийн санхүүжилтийн хосолсон загварыг нэвтрүүлж болох юм. Малайз, Сингапур, Өмнөд Солонгос, Танзани зэрэг оронд мэрэгжлийн ажилчид бэлтгэх үйл явцад ажил олгогчдын зүгээс зохих хэмжээний хандив оруулдаг журамтай. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, ТМБС-ын дэд бүтэц, сургалтын нөхцлийг бүрдүүлэхэд төрөөс биш харин хувийн хэвшил хөрөнгө оруулалт хийхийг хөхүүлэн дэмжих бодлого хэрэгтэй.

Цаашилбал, оюутнуудад олгож байгаа тэтгэлгийн асуудлыг эргэн харах шаардлагатай байж болох юм. Ажил олгогчдын зүгээс өндөр эрэлт хэрэгцээтэй байгаа мэрэгжлээр суралцагчдад тэтгэмжийг илүү хандуулж, хөдөлмөрийн зах зээлд нэгэнтээ хангагдаад байгаа мэрэгжлээр суралцагчдад цөөн тэтгэлэг олгодог болгох талаар авч үзэж болох юм.

Үндэсний чадамжийн бүтэц байгуулах. Эхний ээлжинд төвлөрсөн шалгалт, үнэлгээ, чадамжийн тогтолцоог бий болгох хэрэгтэй. Энэ нь ТМБС тогтолцооны үр дүн тогтвортой байх нөхцлийг хангана. Төвлөрсөн шалгалт, үнэлгээ, чадамжийн тогтолцоог бий болгоход үйлдвэрийн газрын мэрэгжилтнүүдийг татан оролцуулах нь чухал. Эрэлт хэрэгцээнд нийцсэн, чадамжид суурилсан сайтар боловсруулсан кинрикулим болон үйлдвэрийн газруудын оролцоо бүхий шалгалт, үнэлгээ, чадамжийн тогтолцоо нь чанарын батламжийн бат бэх үндэс суурь байх болно. Энэ нь ТМБС-ын бүтээгдэхүүний чанарыг тууштай хангах болно. Урт хугацаанд, Австрали /хайрцаг 8/, Шинэ Зеланд, Англи, Өмнөд Африк зэрэг орнуудад хэрэгжүүлж байгаа үндэсний чадамжийн бүтэцтэй төстэй бүтцийг нэвтрүүлэхийг зорьж болох юм.

Мэдээлэлд мониторинг хийх. Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагын талаар мэдээллээр хангах, шинэчилсэн ТМБС-ын тогтолцооны зах зээлд бэлтгэн гаргаж байгаа бүтээгдэхүүнд мониторинг үнэлгээ хийх хэрэгсэл болгон ашиглах хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн систем бий болгох шаардлагатай байна. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем нь сургуулиуд өөрсдийн төгсөгчдийн мөрөөр жил бүр судалгаа хийж байх ажлыг эрчимжүүлнэ. Төгсөгчдийн мөрөөр хийх судалгаа, ажил олгогчдоос авах мэдээлэл судалгаа болон хөдөлмөрийн зах зээлийн бусад судалгааны мэдээлэл нь нийлээд ТМБС-ын шинэ агентлагийн мэдээлэлд суурилсан бодлого боловсруулалт, стратегийн төлөвлөлтөнд ашиглах цогц мэдээлэл болно.

Дүгнэж хэлэхэд, нэгэнт ТМБС-ын эрэлт хэрэгцээ өндөр байгаа учраас суралцагсдын заримыг энэ дэд салбар руу чиглүүлэх нь ухаалаг алхам байх талтай. Гэхдээ энэ стратеги нь системд хангалттай хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд л амжилттай хэрэгжих боломжтой. Энэ нь хөрөнгө оруулалтын нэмэлт эх үүсвэр шаардахаас гадна дэд салбарын засаглалын чадавхийг сайжруулах, сургалтын чанарыг шинэ шатанд гаргах, үйлдвэрлэлтэй нягт холбож өгөх, төгсөгчдөд ажлын байр олоход нь туслах зэрэг асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна. Дэд бүтэц, тоног төхөөрөмж хангалтгүй, чанарын батламжийн механизм сул, багш нарын мэрэгжил дээшлүүлэх боломж хязгаарлагдмал зэрэг бэрхшээлүүд нь дээд боловсролын дэд салбартай адил төстэй байгаа ч гэсэн ТМБС-ын хувьд байдал илүү хүнд байна. Засгийн газар техник мэрэгжлийн боловсролыг залуусыг дээд боловсролоос дутахгүйгээр татаж чадах тийм хувилбар болгох, ТМБС-ыг хоёр дахь зэрэглэлийн хувилбар мэтээр үзэх нийгэмд тогтсон буруу ойлголтыг арилгах хэрэгтэй. Ажил олгогчдын шаардаж байгаа мэрэгжлийн өндөр ур чадварыг эзэмшсэн Монголчууд /эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд/-ийн тоо олон болоогүй цагт эдийн засгийн

салбаруудад шинэ бүтээмж, өндөр цалин хөлстэй ажлын байр нээгдсэн ч тэдгээр нь иргэдийн амьдралын түвшинд нөлөөлж чадах хүссэн үр дүнг авчирж чадахгүй билээ.

Хайрцаг 8. Австралийн мэрэгжлийн чадамжийн бүтэц

Австралийн мэрэгжлийн чадамжийн бүтэц нь ерөнхий боловсролын ахлах сургууль, мэрэгжлийн боловсрол, сургалтын институтууд, дээд боловсролын институтуудын үндэсний чадамжийн нэгдмэл тогтолцоо юм. Боловсролыг нийт 14 түвшинд авч үдэг:

- Ерөнхий боловсролын ахлах сургуулийн сертификат;
- Сертификат 1;
- Сертификат 2;
